Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

# ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

| Д/д | БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ | ТӨСӨВ | ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ | СУУРЬ ТҮВШИН | ЗОРИЛТОТ ТҮВШИН | ХҮРСЭН ТҮВШИН БУЮУ ХЭРЭГЖИЛТ | ХУВЬ |
|---|---|---|---|---|---|---|---|
| **НЭГ. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | |
| 1 | **Зорилт 1** Иргэдэд зориулсан спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлнэ. (ЗГҮАХ 2.2.3) | 178.5 | Арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Спорт цогцолборын ажлын явц 30% | 100% (Спортын цогцолборын зураг төсөл хийлгэнэ.) | Дүүргийн төсвийн хөрөнгөөр 8 дугаар хороонд "Спорт цогцолборын барилга"-ын зөвлөх үйлчилгээний ажлын явц 50 хувьтай хэрэгжиж байна. | 50% |
| 1.1 | Арга хэмжээ: Спортын цогцолборын барилгын зураг төсөл, төсвийг хийлгэн, барилга угсралтад шаардагдах хөрөнгийг улс, нийслэлийн төсөвт тусгуулахаар уламжилна. | 178.5 | Зураг төсөв хийлгэж, санал уламжилсан эсэх, ажлын явц, хувь | Спорт цогцолборын ажлын явц 30% | 100% /Спортын цогцолборын зураг төсөл, төсвийг хийлгэж, төсөвт тусгуулахаар | Дүүргийн төсвийн хөрөнгөөр 8 дугаар хороонд "Спорт цогцолборын барилга"-ын зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгүүлэхээр "Классик хаус" ХХК- тай гэрээ байгуулсан. Спорт цогцолборын барилга нь 586 үзэгчийн суудалтай. Сагсан бөмбөг, бокс, ресторан, фитнес, хурлын заал, ширээний теннис, ханын | 60% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | санал уламжилсан байна./ | теннис, байт харваа, усанд сэлэлт, шатар даам, бөхийн танхимууд болон бусад дагалдах өрөө тасалгаануудтайгаар төлөвлөгдсөн. Загвар зураг батлагдсан. Ажлын зураг төсөв боловсруулагдаж байна. | |
| 2 | **Зорилт 2**<br>Цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын түвшинг үе шаттайгаар өсгөнө. (ЗГҮАХ 2.3.9.2) | 4,509.9 | Арга хэмжээний хэрэгжилтийн хувь | 2022 онд 2 цэцэрлэг ашиглалтад оруулсан | 100% (2-оос доошгүй цэцэрлэгийн барилгын ажлыг дуусгана.) | Хан-Уул дүүргийн хэмжээнд цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1, 2, 3, 4, 7, 9, 10, 18, 20 дугаар хороонд нийт 1730 орны хүчин чадалтай 9 цэцэрлэгийн барилга, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 4, 8, 16 дугаар хороонд нийт 720 орны багтаамжтай 3 цэцэрлэгийн барилга, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 4, 9, 15, 16 дугаар хороонд нийт 700 орны багтаамжтай 4 цэцэрлэгийн барилгын гүйцэтгэгч шалгаран ажиллаж байна. | 70% |
| 2.1 | Арга хэмжээ: Шинээр 2-оос доошгүй цэцэрлэгийн барилгыг ашиглалтад оруулна. | 4,509.9 | Ашиглалтад орсон цэцэрлэгийн тоо, ажлын явц, хувь | - | 100% (2-оос доошгүй цэцэрлэгийн барилгын ажлыг дуусгана.) | Хан-Уул дүүргийн хэмжээнд цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр нийт 3150 орны багтаамж бүхий 16 цэцэрлэгийн барилгын гүйцэтгэгч шалгаран хэрэгжиж байна.<br>Явцаар нь авч үзвэл:<br>1. 3 дугаар хороо, 240 ортой 4-р цэцэрлэгийн барилга ашиглалтад орсон (УТХО)<br>2. 4 дүгэр хороо, 200 ортой цэцэрлэгийн барилга улсын комисс ажиллах шатанд (ДТХО)<br>3. 9 дүгээр хороо 240 ортой 134-р цэцэрлэгийн барилга улсын комисс ажиллах шатанд (УТХО)<br>4. 16 дугаар хороо, 200 ортой цэцэрлэгийн барилгын барилга угсралтын ажлын явц 70 хувийн гүйцэтгэлтэй (ДТХО)<br>5. 5 дугаар хороо, 150 ор бүхий | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 71-р цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын барилга угсралтын ажлын явц 50 хувийн гүйцэтгэлтэй (УТХО)<br>6. 1 дүгээр хороо, 120 ортой 67 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын барилга угсралтын ажлын явц 30 хувийн гүйцэтгэлтэй (УТХО)<br>7. 4 дүгээр хороо, 100 ортой 145 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын барилга угсралтын ажлын явц 30 хувийн гүйцэтгэлтэй (УТХО)<br>8. 20 дугаар хороо,240 ортой цэцэрлэгийн барилгын барилга угсралтын ажлын явц 30 хувийн гүйцэтгэлтэй (УТХО)<br>9. 1 дүгээр хороо, 240 ортой цэцэрлэгийн барилгын барилга угсралтын ажлын явц 20 хувийн гүйцэтгэлтэй (УТХО)<br>10. 10 дугаар хороо, 200 ортой 49 дүгээр цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын барилга угсралтын ажил 10 хувийн гүйцэтгэлтэй (УТХО)<br>11. 15 дугаар хороо, 200 ортой цэцэрлэгийн барилгын ажлын явц 10 хувийн гүйцэтгэлтэй (ДТХО)<br>12. 8 дугаар хороонд 240 ортой цэцэрлэгийн барилгын зураг төсөв боловсруулагдаж байна (НТХО)<br>13. 16 дугаар хороонд 240 ортой цэцэрлэгийн барилгын зураг төсөв боловсруулагдаж байна (НТХО)-5%<br>14. 18 дугаар хороо, 200 ортой цэцэрлэгийн барилгын зураг төсөв боловсруулагдаж байна /УТХО/-5%<br>15. 23, 24 дүгээр хороо, 240 ортой цэцэрлэгийн барилгын зураг төсөв боловсруулагдаж байна (НТХО)-5%<br>16. 9 дүгээр хороо, 100 ортой | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цэцэрлэгийн барилга гүйцэтгэгч шалгарч гэрээ байгуулсан. (ДТХО) | |
| 3 | **Зорилт 3** Гэр хорооллын өрхүүдийн ундны усны эх үүсвэрийг нэмэгдүүлнэ. (ЗГҮАХ 3.7.11) | 70.0 | Арга хэмжээний хэрэгжилтийн хувь | 2022 онд 5 худаг ашиглалтад оруулсан | 2-оос доошгүй худгийн барилга ашиглалтад орсон байна. | Хан-Уул дүүргийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар он дамжин хэрэгжиж буй 5 гүний худаг шинээр гаргах арга хэмжээнээс 3 гүний худгийн ажил бүрэн дууcч, 2 гүний худгийг 2023 оны 7 дугаар сард ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Мөн дүүргийн 12, 13 дугаар хороонд Мянганы сорилтын сангаас "Улаанбаатар хотын ус хангамжийн баруун шинэ эх үүсвэр" төсөл хэрэгжүүлж эхэлсэн. | 50% |
| 3.1 | Арга хэмжээ: Гэр хорооллын шаардлагатай байршлуудад 2-оос доошгүй ундны усны худгийг ашиглалтад оруулна. | 70.0 | Ашиглалтад орсон худгийн тоо | 2022 онд 5 худаг ашиглалтад оруулсан | 2-оос доошгүй худгийн барилга ашиглалтад орсон байна. | Дүүргийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар он дамжин хэрэгжиж буй 9, 11, 12, 13, 14 дүгээр хороонд шинээр 5 гүний худаг гаргах арга хэмжээнээс 9, 12, 14 дүгээр хорооны 3 гүний худгийн ажил бүрэн дуусаж, 11 дүгээр хорооны гүний худаг хуучин худгийн барилгыг буулгах, 13 дугаар хорооны худаг цахилгааны утас татах шатанд тус тус хэрэгжиж байна. Худгийн ажил 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор дуусгаж, ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн 300.0 сая төгрөгийн хөрөнгөөр 10, 12, 13, 14 дүгээр хороодын 17 гүний худагт смарт төхөөрөмж суурилуулах ажлын эхний тендер амжилтгүй болсон тул Үнэлгээний хороо захиалагчаас ажлын даалгаварт тодруулга авч, худгийн тоог 13 болгож, дахин тендер зарласан бөгөөд 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдөр нээлт хийнэ. | 50% |
| 4 | **Зорилт 4** Хороолол дундах зам талбайн ус зайлуулах сувгууд болон үерийн далан | 672.9 | Арга хэмжээний хэрэгжилтийн хувь | 2022 онд 2,4 км урт ус зайлуулах суваг хийгдсэн. | 0.6 км-ээс доошгүй ус зайлуулах суваг | Дүүргийн төсвийн хөрөнгөөр 16 дугаар хороонд “Бороны ус зайлуулах шугам сүлжээний ажил”-ын гүйцэтгэгчээр “Нүнжиг” ХХК шалгарч, гэрээ байгуулсан. Ажил эхлүүлэх зөвшөөрөл олгож байна. | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хамгаалалтыг шинээр бий болгоно. (ЗГҮАХ 3.7.12) | | | | ашиглалтад орсон байна. | Геодези, усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ авто замын ус зайлуулах шугамын 12 худгийн тагийг нөхөж шинэчилсэн, 3 байршил ус зайлуулах шугамын засвар, шинэчлэлт, 21 дүгээр хороо 0.15 км үерийн хамгаалалтын далангийн ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр ажиллаж байна. | |
| 4.1 | Арга хэмжээ: Шаардлагатай байршилд ус зайлуулах суваг байгуулсан байна. | 672.9 | Ашиглалтад орсон ус зайлуулах сувгийн урт | 2022 онд 2,4 км урт ус зайлуулах суваг хийгдсэн | 0.6 км-ээс доошгүй ус зайлуулах суваг ашиглалтад орсон байна. | Дүүргийн төсвийн хөрөнгөөр 16 дугаар хороонд "Борооны ус зайлуулах шугам сүлжээний ажил"-ын гүйцэтгэгчээр "Нүнжиг" ХХК шалгарч, гэрээ байгуулсан. Ажил эхлүүлэх зөвшөөрөл олгохоор ажиллаж байна.<br>Геодези, усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ дүүргийн 2, 9, 10, 15 дугаар хороонд авто замын ус зайлуулах шугамын 12 худгийн тагийг нөхөж шинэчилсэн, Наадамчдын замын ус зайлуулах 430 урт метр, 3 дугаар хороонд Үйлдвэрийн гудамжны 497 урт метр, 18 дугаар хороо Гэгээнтэн орчимд ус зайлуулах шугамын засвар, шинэчлэлтийн ажлыг гүйцэтгэхээр ажиллаж байна. Мөн тус байгууллагаас үерийн хамгаалалтын барилга байгууламжийн үзлэг шалгалтаар 6 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад зөрчил арилгах талаар албан мэдэгдэл хүргүүлсэн. Дүүргийн 21 дүгээр хороонд хэрэгжиж буй Жаргалантын амны үерийн хамгаалалтын барилга байгууламжийн ажлын үргэлжлэл 0.15 км далангийн ажил хэрэгжихээр төлөвлөгдсөн байна. | 50% |
| 5 | **Зорилт 5**<br>Нийтийн эзэмшлийн зам талбайн болон хогийн цэг, хайрга, дайрга олборлолт, тээвэрлэлтийг хянаж, | 1,273.9 | Арга хэмжээний хэрэгжилтийн хувь | - | 100% (200-аас доошгүй байршилд | Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан, дүүргийн төсөв, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр он дамжин хэрэгжиж буй 6 төсөл арга хэмжээ ажил гүйцэтгэх шатанд, 2023 онд дүүргийн | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зохицуулах цэгүүдийн камержуулалтыг нэмэгдүүлнэ. /ЗГҮАХ 4.3.2/ | | | | камержуулсан байна.) | төсвийн хөрөнгөөр шинээр хэрэгжих 1 төсөл арга хэмжээ гүйцэтгэгч шалгаруулах шатанд хэрэгжиж байна. | |
| 5.1 | Арга хэмжээ: Дүүргийн хэмжээнд 200-аас доошгүй камер суурилуулж, хуучирч муудсан камеруудыг сэргээн засварлана. | 1,273.9 | Суурилуулсан камерын тоо, ажлын явц, хувь | - | 100% (200-аас доошгүй байршилд камержуулсан байна.) | Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан, дүүргийн төсөв, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд нийтийн эзэмшлийн гудамж талбайг камержуулах, орчны аюулгүй байдлыг хангах чиглэлээр хэрэгжих 6 төсөл арга хэмжээний хүрээнд нийт 340 ширхэг камер суурилуулахаар төлөвлөсөн. Үүнд:<br>1. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны хөрөнгөөр хэрэгжиж буй "Камержуулалт (12, 13, 14-р хороодод 80 ширхэг)-ын ажил гүйцэтгэгч шалгаруулах шатанд;<br>2. Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй "Хайрга, дайрга олборлолт, тээвэрлэлтийг хянаж, зохицуулах цэгүүдийн тусгай зориулалтын 10 ширхэг камержуулалт (12, 13, 14, 16, 21-р хороо)"-ын ажил 90 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна.<br>3. Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 2020 оны хөрөнгөөр хэрэгжиж буй "Камержуулалт (1, 2, 3, 6, 7, 8, 17, 19-р хороодод 53 ширхэг)"-ын ажлын гүйцэтгэгчээр "Инносольюшн" ХХК шалгарч, гэрээ байгуулан зураг төсөл боловсруулж, магадлал хийх шатанд хэрэгжиж байна.<br>4. Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны хөрөнгөөр хэрэгжиж буй "Камержуулалт (1-5, 9-11, 13-21-р хороодод 117 ширхэг)"-ын ажил 90 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Гүйцэтгэгч "Арш технологи" ХХК.<br>5. Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны хөрөнгөөр хэрэгжиж | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | буй "Камержуулалт (4-10, 12, 13, 14, 16, 21-р хороодод 80 ширхэг)-ын ажлын гүйцэтгэгчээр "Инносольюшн" ХХК шалгарч гэрээ байгуулсан зураг төсөл боловсруулах шатанд хэрэгжиж байна.<br>6. Дүүргийн төсвийн 2023 оны 1.0 тэрбум төгрөгийн хөрөнгөөр хэрэгжих "Камерын хяналтын төв, камержуулалтын ажил (Нисэхийн бүс)"-ын гүйцэтгэгч шалгаруулах тендер 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдөр нээхэд 3 аж ахуйн нэгж оролцсноос шаардлага хангахгүй тул татгалзсан. Дахин тендер зарлахаар ажиллаж байна. | |
| 6 | **Зорилт 6**<br>Замын хөдөлгөөний нягтралыг сарниулж, ачааллыг тэнцвэржүүлсэн, авто замыг шинээр байгуулна. (ЗГҮАХ 6.1.6) | 6,424.2 | Арга хэмжээний хэрэгжилтийн хувь | 2022 онд 5,2 км авто зам ашиглалтад оруулсан | 5 км-ээс доошгүй хатуу хучилттай авто зам тавигдсан байна. | Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр дүүргийн 3, 8, 9, 16, 17, 19, 23, 25 хорооны 8 байршилд 9.75 км хатуу хучилттай авто зам, засвар, шинэчлэлийн ажил хэрэгжиж байна. | 50% |
| 6.1 | Арга хэмжээ: Дүүргийн авто замын ачааллыг тэнцвэржүүлэх, зорчих хэсгийг сайжруулах зорилгоор 5 км-ээс доошгүй хатуу хучилттай авто замыг ашиглалтад оруулна. | 6,424.2 | Шинээр тавьсан авто замын урт/км | 2022 онд 5,2 км авто зам ашиглалтад оруулсан | 5 км-ээс доошгүй хатуу хучилттай авто зам тавигдсан байна. | Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр дүүргийн 3, 8, 9, 16, 17, 19, 23, 25 хорооны 8 байршилд 9.75 км хатуу хучилттай авто зам, засвар, шинэчлэлийн ажил хэрэгжиж байна. Үүнд:<br>1. Улсын төсвийн хөрөнгөөр 16, 25 дугаар хороонд хэрэгжиж буй Нисэхийн эцсийн автобусны буудлаас Сонсголонгийн төв зам хүртэлх 2.2 км авто замын суурь, бродюрын ажил хийгдэж, 50 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна.<br>2. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 3 дугаар хороонд хэрэгжиж буй Чингисийн өргөн чөлөөнөөс Баруун үйлдвэрийн гудамж хүртэлх 2.2 км авто зам, гүүрийн барилгын ажлын газар шорооны ажил эхэлж, 20 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 3. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 19 дүгээр хороонд хэрэгжиж буй Ээрмэлийн гудамжийг Туул гол гудамжтай холбох авто замын ажил явган хүний зам тавих, гэрэлтүүлэг суурилуулах шатанд 90 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна.<br>4. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 9, 16 дугаар хороонд хэрэгжүүлэх 1.4 км хатуу хучилттай авто зам тавих ажлын тендерт 5 аж ахуй нэгж материал ирүүлсэн бөгөөд, тендерт тавигдах шаардлага хангаагүй тул бүх аж ахуй нэгжээс татгалзсан. Тендер дахин зарлах шатанд.<br>5. Дүүргийн төсвийн 1,622.2 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй "Наадамчдын замаас Нэгдсэн эмнэлгийн уулзвар хүртэл авто замын засвар, шинэчлэлт"-ийн ажлын гүйцэтгэгчээр "Мегатитан" ХХК шалгарсан бөгөөд замын трасс дагуух гэрэлтүүлэг болон дэд бүтцийн шугам сүлжээг шилжүүлэх газар чөлөөлөлтийн шатанд хэрэгжиж байна.<br>6. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 8 дугаар хороонд хэрэгжүүлэх Чингисийн хүрээний авто замаас Эко ахмадын сувилал хүртэлх авто замын ажлын тендерийг 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдөр нээхэд 7 аж ахуй нэгж материал ирүүлсэн, тендерийн баримт бичигт үнэлгээ хийгдэж байна.<br>Дүүргийн авто замын засвар, шинэчлэлтийн ажлын хүрээнд Хан-Уул зам засвар, арчлалт ОНӨААТҮГ-ын хэрэгжүүлж буй 19, 20 дугаар хороонд 27 дугаар цэцэрлэгийн хойд уулзвараас Монгол нэхмэл ХХК хүртэл 0.76 км хатуу хучилттай авто замын ажил 70 хувийн гүйцэтгэлтэй, 9, 10, 12 дугаар хороонд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэрэгжих 2.2 км авто замын ажил зураг төсөл боловсруулагдаж, холбогдох мэргэжлийн байгууллагуудтай зөвшилцөх шатанд хэрэгжиж байна. | |
| 7 | **Зорилт 7**<br>Явган хүний болон унадаг дугуйн зам, авто машины зогсоол, хүүхдийн тоглоомын талбай барьж байгуулан, тоосжилтыг бууруулна. (ЗГҮАХ 6.1.7) | 6,508.3 | Арга хэмжээний хэрэгжилтийн хувь | 2022 онд 15 байршилд тохижилтын ажил хийгдэж, 9,4 км урт явган хүний зам ашиглалтад оруулсан | 4-өөс доошгүй байршилд тохижилтын ажил хийж, 5 км-ээс багагүй урт явган хүний зам шинээр тавьсан байна | Дүүргийн төсвийн 2023 оны хөрөнгөөр хэрэгжих 8 төсөл арга хэмжээний хүрээнд 12 байршилд хэрэгжих тохижилт, 19 байршилд нийт 10.6 км явган хүний зам, 1 км дугуйн зам, талбайн засвар, шинэчлэлтийн ажил гүйцэтгэгч шалгаруулах, гэрээ байгуулах шатанд хэрэгжиж байна.<br>Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй 19 дүгээр хороонд 27/1 байрны гадна тоглоомын талбайн засвар шинэчлэлт, 18 дугаар хороонд 29, 30 дугаар байрны гадна талбайн тохижилт, 22 дугаар хороо Зайсангийн автобусны буудлын тохижилтын ажил 30 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. | 50% |
| 7.1 | Арга хэмжээ: Шинээр 4-өөс доошгүй байршилд тохижилт, бүтээн байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэнэ. | 3,732.2 | Тохижилт хийгдсэн байршлын тоо | 2022 онд 15 байршилд тохижилтын ажил хийгдсэн | 4-өөс доошгүй байршилд тохижилтын ажил хийнэ. | Дүүргийн төсвийн 5.2 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 1, 2, 5, 7, 8, 10, 13, 14, 16 дугаар хороодын 11 байршилд тохижилтын чиглэлээр 2023 онд шинээр хэрэгжих 8 төсөл арга хэмжээнээс 4 төсөл арга хэмжээ гүйцэтгэгч сонгон шалгаруулах шатанд, 3 төсөл арга хэмжээ гэрээ байгуулах шатанд, 1 төсөл арга хэмжээ гэрээ байгуулагдсан байна.<br>Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 309.2 сая төгрөгийн хөрөнгөөр он дамжин хэрэгжиж буй орчны тохижилтын 2 төсөл арга хэмжээ ажил гүйцэтгэх шатанд байна.<br>Тухайлбал дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй 19 дүгээр хороонд 27/1 байрны гадна тоглоомын талбайн засвар шинэчлэлт, 18 дугаар хороонд 29, 30 дугаар байрны | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гадна талбайн тохижилт, 22 дугаар хороо Зайсангийн автобусны буудлын тохижилтын ажил, 1, 2, 3 дугаар хороодын явган хүний зам талбайн засвар шинэчлэлтийн ажил тус тус 30 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. | |
| 7.2 | Арга хэмжээ: Дүүргийн нийтийн эзэмшлийн зам талбайд 4 км-ээс багагүй урт явган хүний замыг шинэчлэн засварлана. | 2,776.1 | Шинээр тавьсан явган хүний замын урт | 2022 онд 9,4 км урт явган хүний зам ашиглалтад оруулсан | 5 км-ээс багагүй урт явган хүний зам шинээр тавьсан байна | Явган хүний зам талбайн засвар шинэчлэлтийн ажлын хүрээнд дүүргийн төсөв, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 1, 2, 3, 11, 15, 19, 20, 22, 23, 24 дүгээр хорооны 19 байршилд нийт 10.6 км явган хүн зам талбайн засвар, шинэчлэлтийн чиглэлээр 7 төсөл арга хэмжээ хэрэгжихээр төлөвлөгдсөнөөс 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар 2 төсөл арга хэмжээний тендер зарлагдсан, 2 төсөл арга хэмжээ гэрээ байгуулах шатанд, 3 төсөл арга хэмжээ ажил гүйцэтгэх шатанд хэрэгжиж байна.<br>Дунд гол гудамжны авто замын хойд хэсгийн 2500 метр урт явган зам, Хөдөө аж ахуйн их сургуулийн автобусны буудлын 150 метр урт явган замын засвар, шинэчлэлт ажил гүйцэтгэх шатанд хэрэгжиж байна. | 50% |
| 8 | **Зорилт 8**<br>Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх, ил тод байдлыг сайжруулах, олон нийт оролцох, мэдээлэл хүргэх дэвшилтэт арга хэлбэрийг нэвтрүүлнэ. (ЗГҮАХ 6.2.6) | - | Санал асуулга зохион байгуулсан эсэх | - | Цахим санал асуулга зохион байгуулсан байна. | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг иргэдээс цахимаар авах ажлын бэлтгэл хангаж, санал асуулгыг зохион байгуулан ажиллаж байна. | 70% |
| 8.1 | Арга хэмжээ: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд иргэдээс авах санал асуулгыг цахим | - | Цахим санал асуулга зохион байгуулсан эсэх | - | Цахим санал асуулга зохион байгуулсан байна. | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хийгдэх төсөл арга хэмжээнд иргэд олон нийтээс цахимаар санал авах ажлын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс 2022 оны 06 дугаар | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | аппликейшн ашиглан зохион байгуулна | | | | | сарын 05-ны өдрийн хооронд зохион байгуулсан. Санал асуулга явагдаж буй хугацаанд хороодын зохион байгуулагч, хэсгийн ахлагч нарт шинээр аппликейшин ашиглалтад орсонтой холбоотойгоор Орон нутгийн хөгжлийн сангийн санал асуулгын явцын мэдээллийг танилцуулж, "e-mongolia", "Орон нутгийн хөгжлийн сан" аппликейшинээр санал өгөх заавар зөвлөмж өгч ажилласан. Мөн иргэдийг идэвхтэй хамруулж, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "Орон нутгийн хөгжлийн сангийн цахим санал асуулга" удирдамж батлан хороо, зохион байгуулагч, хэсгийн ахлагчдын дунд болзолт уралдаан зарласан. 2023 оны 05 дугаар сарын 25-ны байдлаар 17,773 иргэн санал өгөөд байна. | |
| 9 | **Зорилт 9** Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг хангуулж ажиллана. | - | Арга хэмжээний хэрэгжилтийн хувь | 92.5% | 90%-аас доошгүй хувьтай хэрэгжсэн байна. | Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс Хан-Уул дүүрэг хамтран хэрэгжүүлэх 2 бүлгийн 5 арга хэмжээ, хяналт шинжилгээ, үнэлгээний 2 шалгуур үзүүлэлтийн 1 дүгээр улирлын тайланг тус тус холбогдох байгууллагад хугацаанд хүргүүлж, тайлагнасан. Хагас жилийн биелэлт тайлагнах хугацаа болоогүй. | 30% |
| 9.1 | Арга хэмжээ: Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөөс Хан-Уул дүүрэг хамтран хэрэгжүүлэх заалтуудын биелэлт, хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг хангуулж, тухай бүр тайлагнаж ажиллана. | - | Хэрэгжилтийн хувь | 2022 онд 4 удаа тайлагнаж, жилийн эцсийн биелэлт 92.5 хувьтай хэрэгжсэн. | 90%-аас доошгүй хувьтай хэрэгжсэн байна. | Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс тус дүүрэг хамтран хэрэгжүүлэх 2 бүлэг, 2 зорилго, 3 зорилт, 4 арга хэмжээ 52,5 хувьтай хэрэгжиж, хяналт-шинжилгээ, үнэлгээний 2 шалгуур үзүүлэлт 50% хувьтай үнэлэгдсэн. | 50% |
| 9.2 | Арга хэмжээ: Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн | - | Хэрэгжилтийн хувь | 2022 онд 1 удаа | 90%-аас доошгүй | Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2023 оны | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үндсэн чиглэлээс Хан-Уул дүүрэг хамтран хэрэгжүүлэх заалтуудын биелэлтийг хангуулж, тухай бүр тайлагнаж ажиллана. | | | тайлагнаж, жилийн эцсийн биелэлт 100 хувьтай хэрэгжсэн. | хувьтай хэрэгжсэн байна. | төлөвлөгөөний 1 бүлэг, 2 зорилт, 4 арга хэмжээ 45 хувьтай биелсэн.<br>Монгол улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний 1 бүлэг, 1 зорилт, 3 арга хэмжээ 50 хувьтай хэрэгжжээ. Хагас жилийн биелэлтийг хяналт шинжилгээ үнэлгээний шалгуур үзүүлэлтийн тайлангуудын хамт 2023 оны 06 дугаар сарын 02-ны удирдлагад танилцуулан нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн холбогдох мэргэжилтэнрүү цахимаар илгээж, тайлагнасан. | |
| 9.3 | Арга хэмжээ: Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлээс Хан-Уул дүүрэг хамтран хэрэгжүүлэх заалтуудын биелэлт, хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн тайлан | | Хагас бүтэн жилээр хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тоо | 2 удаа хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, холбогдох албан тушаалтанд танилцуулж, тайлагнасан. | 2 удаа хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, холбогдох албан тушаалтанд танилцуулж, тайлагнасан байна. | Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтээс Хан-Уул дүүрэг 2023 онд хамтран хэрэгжүүлэх 1 арга хэмжээ хагас жилийн байдлаар 100 хэрэгжсэн бөгөөд тайланг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хугацаанд нь цахимаар илгээсэн. | 50% |
| 10 | **Зорилт 10**<br>Улаанбаатар хотын агаарын бохирдлыг 80 хувь хүртэл бууруулж, бусад томоохон хот, суурин газрын агаарын бохирдлын асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ. (ЗГҮАХ 5.1.1) | | Арга хэмжээний хэрэгжилт, хувь | 88.3% /6 арга хэмжээ 88.3 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжинэ/ | 90% /6 арга хэмжээг 90.0%-иас доошгүй гүйцэтгэлтэй хэрэгжинэ./ | Дүүргийн 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 16, 23, 25 дугаар хороодын гэр хорооллын айл өрхүүдийг сайжруулсан шахмал түлшээр хангах 50 борлуулалтын цэгийг байгуулж, хяналт тавьж ажиллаж байна. Утааны эх үүсвэрийн улсын тоо бүртгэлийг явуулж, зуухны тоо мэдээллийг цахим мэдээллийн санд бүртгэсэн. Дүүргийн Засаг даргын 2022 оны А/576 дугаар захирамжаар Шуурхай штабыг байгуулж, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулж ажиллаж байна. | 80% |
| 10.1 | Арга хэмжээ: Гэр хорооллын айл өрхүүдийг стандартын | - | Борлуулалтын цэгийн тоо | Сайжруулсан түлшний | 50-аас доошгүй | Дүүргийн 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 16, 23 дугаар хороодод сайжруулсан | 80% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шаардлага хангасан түлшээр хангах борлуулалтын цэг, хангамжийн баазуудыг байгуулж, хэвийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллана. | | | борлуулалтын 53 цэг байгуулсан. | сайжруулсан түлшний борлуулалтын цэг байгуулж, хяналт тавьж ажиллана. | шахмал түлшний 50 борлуулалтын цэгийг байгуулж, түгээлт, борлуулалт, нийлүүлэлтэд тогтмол хяналт тавьж ажиллаж байгаа бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 24-ний өдөр хүртэл хугацаанд хэрэглэгчдийг 20,215 тн сайжруулсан түлшээр хангасан. | |
| 10.2 | Арга хэмжээ: Төрийн өмчийн халаалтын зуухнуудыг үе шаттайгаар төвлөрсөн дулаанд холбоно. | Гадаадын зээл тусламж | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | | 100% | "Цэвэр агаар" төслийн санхүүжилтээр "Хоёулаа миний хүү" ХХК-ийн уурын зуухнаас халаалт авдаг 6 дугаар хорооны байр, Цагдаагийн 2 дугаар хэлтэс, дүүргийн Нэгдсэн амбулатор, Шуудан холбоо зэрэг байгууллагуудыг төвлөрсөн халаалтад шилжүүлэх ажил дулааны үзелийн барилга барих, шугам сүлжээний газар шорооны ажил эхлэх шатанд хэрэгжиж байна. | 50% |
| 10.3 | Арга хэмжээ: Дүүргийн хэмжээнд агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлийг зохион байгуулж, цахим бүртгэлийн санд оруулна. | - | Нэгдсэн тоо бүртгэлд хамруулсан хорооны тоо | 13 хороо /4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 16, 21 дүгээр хороо/-г тооллогод хамруулж, 17090 өрхийн мэдээллийг шинэчилж, цахим бүртгэлийн санд оруулсан. | 13 хороог тооллогод хамруулж (4, 5, 6, 7, 8, 9, 10, 12, 13, 14, 16, 22 дугаар хороо), мэдээллийг цахим бүртгэлийн санд оруулна. | Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1561 дүгээр захирамжийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд утааны эх үүсвэрийн улсын тоо бүртгэлийг 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдөр хүртэл хугацаанд явуулж, 3-15 кВт хүчин чадалтай зуухтай 16,228, 15-100 кВт хүчин чадалтай зуухтай 705 өрх, аж ахуйн нэгж, байгууллага, 100-4200 кВт хүчин чадалтай уурын халаалтын зуухны байгууламжийн 53 зуухыг тоолж, цахим мэдээллийн санд оруулсан. | 100% |
| 10.4 | Арга хэмжээ: Гэр хорооллын айл өрхүүдийг агаартах эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөмж, сэрэмжлүүлэг хүргэх ажил зохион байгуулна. | - | Зохион байгуулсан арга хэмжээ, тоо | 3 удаагийн аян, арга хэмжээг зохион байгуулж, 65000 ширхэг зөвлөмж | 2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулна. | Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1349, А/1357 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах, утааны хийн хордлогоос урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын 2022 оны А/576 дугаар захирамжаар Онцгой байдлын хэлтэс, Эрүүл мэндийн төв, | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | сэрэмжлүүлэг хүргэсэн. | | | Цагдаагийн газар, Агаарын бохирдолтой тэмцэх тасгийн бүрэлдэхүүнтэй Шуурхай штабыг 2023 оны 02 дугаар сарын 26-ны өдрөөс 04 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл хугацаанд ажиллуулж, сайжруулсан түлшний нөөц, түгээлт, борлуулалт, угаарын хийн хордлогын дуудлага, нөхцөл байдлын талаар өдөр бүр 2 удаа Төв штабд мэдээлэл хүргүүлсэн.<br>Гэр хорооллын 15 хорооны цахим хаягаар өдөрт 3 удаагийн давтамжтай Угаарын хийн хорлогоос урьдчилан сэргийлэх 6 төрлийн зөвлөмж мэдээллийг тогтмол хүргэж ажилласан.<br>Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг дүүргийн хэмжээнд 2023 оны 1, 2 дугаар сард 2 удаа зохион байгуулж, нийт 324 иргэнийг хамруулсан. Гэр хорооллын 17000 гаруй өрхөд 3 удаа 51000 гаруй гарын авлага, өгч зөвлөмжийг хүргүүлсэн.<br>Цагдаагийн 2 дугаар хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Таван толгой түлш ХХК-тай хамтран 4, 5, 6, 7, 8, 9, 10, 12, 13, 14, 16 дугаар хорооны өндөр настан ганц бие, олон хүүхэдтэй зэрэг угаартах эрсдэл бүхий 948 өрхөд "Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, угаар мэдрэгчээ зөв ажиллуулах, зууханд дулаан баригч бортого суурилуулах талаар сургалтуудыг зохион байгуулсан. Тус ажлын хүрээнд угаарын хийн мэдрэгчийг зөв ажиллуулах, зуухны битүүмжлэлийг сайжруулах чиглэлээр зөвлөмж өгч 16228 өрхөөс угаарын хийн мэдрэгчгүй байсан 1969 өрхийг 100 хувь угаар мэдрэгчтэй болгож, 9, 10, 12, 14 дүгээр хорооны өндөр настай 566 иргэний зууханд дулаан баригч бортого | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | суурилуулж өгсөн. Шуурхай штаб ажиллах хугацаанд 40 иргэн угаарын хийн хордлогод өртөж, эрүүл мэндийн байгууллагад хандаж, 31 иргэн нь тусламж авч буцсан, 9 иргэн нь хэвтэн эмчлүүлсэн байна. | |
| 10.5 | Арга хэмжээ: Дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгжүүдийн 100 кВт-аас дээш хүчин чадалтай халаалтын уурын зуухнуудад хяналт шалгалтыг зохион байгуулах. | - | Зохион байгуулсан хяналт шалгалтын тоо | 18 халаалтын зууханд хяналт шалгалт хийж, магадлан итгэмжилсэн. | 18 тусгай зөвшөөрөлтэй уурын зуухнуудад хяналт шалгалт хийнэ. | Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1561 дүгээр захирамжийн хүрээнд хэрэгжүүлсэн утааны эх үүсвэрийн улсын тоо бүртгэлийн ажлын хүрээнд 100-4200 кВт хүчин чадалтай уурын халаалтын зуухны байгууламжийн 53 зуухыг тоолж, цахим мэдээллийн санд оруулсан. | 100% |
| 10.6 | Арга хэмжээ: Агаарын бохирдлын эх үүсвэр, хор уршиг, дэвшилтэт техник, технологи, ногоон амьдралын хэв маягийн талаар танин мэдүүлэх, зөв дадал хэвшилд сургах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулна. | - | Зохион байгуулсан арга хэмжээ, тоо | 2 арга хэмжээ зохион байгуулсан. | 2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулна. | Агаарын бохирдлыг бууруулах, зөв дадал хэвшүүлэх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "Байгальд ээлтэй дэвшилтэт техник технологийн үзэсгэлэн худалдаа" арга хэмжээг 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн бүсчлэн зохион байгуулахаар удирдамж, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. | 30% |
| 11 | **Зорилт 11**<br>Гэр хороолол болон аялал жуулчлалын бүсэд "Эко жорлон" арга хэмжээг хэрэгжүүлж, хөрсний бохирдлыг бууруулна. (ЗГҮАХ 5.1.4) | УТХО | Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламж, тоо | 1304 ширхэг ариун цэврийн байгууламж | Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг 1500-д хүргэнэ | Улсын төсвийн хөрөнгөөр 8, 9, 10 дугаар хороодод нийт 551 эко жорлон барихаас 534 ширхэг жорлонгийн нүх ухаж, 164 нүхэнд кольцо суурилуулж, 18 ширхэг жорлонд нь бүхээг тавьж ашиглалтад оруулсан.<br>Дүүргийн хэмжээнд гэр хорооллын айл өрхийн стандартын шаардлага хангасан, хөрсөнд нэвчилтгүй 1439 ширхэг нүхэн жорлон байна. | 70% |
| 11.1 | Арга хэмжээ: Гэр хорооллын айл өрхүүдэд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг | УТХО | Стандартын шаардлага хангасан ариун | 1304 ширхэг ариун цэврийн байгууламж | Стандартын шаардлага хангасан ариун | Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй Туул гол орчмын хөрсний бохирдлыг бууруулах эко жорлон барих ажлын гүйцэтгэгчээр "Оргил-Өргөө" ХХК | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нэвтрүүлж, хөрсний бохирдлыг бууруулна. | | цэврийн байгууламж, тоо | | цэврийн байгууламжийг 1500-д хүргэнэ | шалгарсан бөгөөд дүүргийн 8, 9, 10 дугаар хороодод нийт 551 эко жорлон барихаас 534 ширхэг жорлонгийн нүх ухаж, 164 нүхэнд кольцо суурилуулж, 18 ширхэг жорлонд нь бүхээг тавьж ашиглалтад оруулсан байна.<br>Хөрсний бохирдлыг бууруулах ажлын хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт стандартын шаардлага хангахгүй нүхэн жорлонг буулгах ажлыг зохион байгуулж, 14 дүгээр хороонд Айцын даваанаас Кувейтын ам хүртэлх авто зам дагуу, 8, 21 дүгээр хороонд Жаргалантын ам руу салдаг уулзвараас Айцын даваа хүртэл авто зам дагуу 9 ширхэг ил задгай нүхэн жорлонг буулгаж, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээ авч ажилласан.<br>Дүүргийн хэмжээнд 2023 оны 05 дугаар сарын байдлаар гэр хорооллын айл өрхийн стандартын шаардлага хангасан, хөрсөнд нэвчилтгүй 1439 ширхэг нүхэн жорлон байна. | |
| 12 | **Зорилт 12**<br>Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна. /ЗГҮАХ 2.1/ | - | Арга, хэмжээний хэрэгжилтийн хувь | Эрүүл мэндийн үйлчилгээнд цахим технологийг нэвтрүүлсэн. | Эрүүл мэндийн үйлчилгээнд нэвтрүүлэх шинэ технологийн тоог нэмэгдүүлнэ. | Өвчнөөс урьдчилан сэргийлэх, иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах ажлын хүрээнд Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлэгт 7 төрлийн тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийгдсэн. Шинээр Хавдрын кабинет, Дотоод шүүрлийн кабинетыг нээж үйл ажиллагаагаа өргөтгөсөн. Эрт илрүүлэг, оношилгоо шинжилгээнд ходоодны дурангийн шинжилгээг хийж үйл ажиллагааг жигдрүүлсэн. Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв дижитал рентген аппарат, ходоодны уян дуран, 4D Эхо аппарат, 12 сувагтай зүрхний бичлэгийн аппарат ашиглаж байна. | 30% |
| 12.1 | Арга хэмжээ: Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, урьдчилан | - | Үзлэг оношилгоонд | Үзлэг, оношилгоонд | Үзлэг, оношилгоонд | 2023 оны эхний 4 сарын статистик тоон үзүүлэлтээр халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг оношилгоонд дүүргийн | 30% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоонд хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | | хамрагдсан иргэдийн тоо | 58214 иргэн хамрагдсан. | хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | хэмжээнд 126176 иргэн хамрагдахаас 26859 иргэн буюу 18.7% хамрагдсан. Үүнээс эрэгтэй 9381, эмэгтэй 17478 иргэн, шинээр оношлогдсон 112, давтан үзлэгт 6116 иргэн үзлэг, оношилгоонд хамрагдсан байна. Артерийн даралт ихсэх өвчин, чихрийн шижин, хэв шинж-2, эрт илрүүлэг үзлэгт 25234 иргэн буюу 17.5% Үүнээс эрэгтэй 8887, эмэгтэй 16347 шинээр оношлогдсон 6, давтан үзлэгт 2300 иргэн хамрагдсан. Умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэг, оношилгоонд 14301 нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд хамрагдахаас 2536 эмэгтэй буюу 18% нь хамрагдсан байна. Хөхний үзлэг оношилгоонд хамрагдвал зохих 58138 хүн хамрагдахаас 18961 хүн буюу 33% хамрагдаж байна. | |
| 13 | **Зорилт 13**<br>"Эрүүл чийрэг эр хүн" арга хэмжээг хэрэгжүүлнэ. | - | Урьдчилан сэргийлэх , үзлэгт хамрагдсан эрэгтэйчүүдийн тоо | 3500 гаруй өсвөр үе, хүүхэд, залуучуудыг хамруулсан. | Өсвөр үе, хүүхэд, залуучуудыг 6000-д хүргэж хамруулна. | "Харилцан хүндэтгэе" аяны хүрээнд эрэгтэйчүүдийн зонхилон тохиолдох өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох 4 төрлийн цахим мэдээ, мэдээллийг Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, 25 хорооны Өрхийн эрүүл мэндийн төвийн цахим хаягаар 3000 гаруй иргэдэд түгээж ажилласан. Эрүүл мэндийн төв мэс заслын 1 эмчийг урологийн чиглэлээр мэргэжил дээшлүүлэх 6 сарын сургалтад хамруулж, 2023 оны 6 дугаар сараас үйл ажиллагаа эхлүүлэх бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна. | 50% |
| 13.1 | Арга хэмжээ: Дүүргийн Нэгдсэн эмнэлэгт Эрэгтэйчүүдийн кабинет байгуулна. | 20.0 | Гүйцэтгэлийн хувь | НЭМГ-ын 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан. | Кабинет байгуулж, үйл ажиллагааг эхлүүлнэ. | Эрэгтэйчүүдийн кабинетыг байгуулах бэлтгэл ажлын хүрээнд мэс заслын 1 эмчийг урологийн чиглэлээр мэргэжил дээшлүүлэх 6 сарын сургалтад 2022 оны 11 дүгээр сараас хамруулж, 2023 оны 6 дугаар сараас үйл ажиллагаа эхлүүлэх бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна. Нэгдсэн эмнэлгийн эрэгтэйчүүдийн | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | кабинетын засварын ажил хийгдэж байна. | |
| 14 | **Зорилт 14**<br>Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангаж, махны экспортын хэмжээг нэмэгдүүлнэ. /ЗГҮАХ 3.3.3/ | - | Өргөтгөсөн худалдаа зохион байгуулсан байршлын тоо, борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ | 459.1 тн мах, 920 тн хүнсний ногоо худалдан борлуулсан. | Мах, төмс, хүнсний ногооны өргөтгөсөн худалдаа зохион байгуулагдсан байна. | Хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор нөөцийн махны худалдааг зохион байгуулж, мах, чанар, аюулгүй байдалд хяналт тавьж, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэн ажилласан. | 100% |
| 14.1 | Арга хэмжээ: Иргэдийн хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор мах, ногооны өргөтгөсөн худалдаа зохион байгуулж ажиллана. | • | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 8 удаагийн арга хэмжээнд 49 байршилд 459.1 тн мах, 920 тн хүнсний ногоо худалдан борлуулсан. | 8-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулна. | Дүүргийн хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр:<br>• Үнийн тогтвортой байдлыг хангах, хэрэглэгчдийг үнэн зөв мэдээллээр хангах зорилгоор худалдаа, үйлчилгээний 140 гаруй газарт хяналт шалгалтыг зохион байгуулж, зөрчлийг арилгуулан, зөвлөн тусалж ажилласан.<br>• Нөөцийн махны худалдааг хүнсний дэлгүүр, сүлжээ 33 дэлгүүрээр жижиглэнгээр 52.9 тонн, өргөтгөсөн худалдаагаар 141.9 тонн нийт 194.8 тонн махыг худалдаалах ажлыг зохион байгуулж, махны чанар аюулгүй байдалд хяналт тавьж, иргэдийн гомдол санал хүсэлтийг тухай бүр шийдвэрлэж ажилласан.<br>Өрхийн орлогын нэмэгдүүлэх, бизнес эрхлэх сонирхолтой иргэдийг дэмжиж улирлын чанартай түр худалдааг 2 байршилд зохион байгуулж, 36 иргэнийг дэмжиж ажилласан. | 100% |
| Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 14 зорилт 54%, 22 арга хэмжээ 59.5% хэрэгжсэн. | | | | | | | |
| **ХОЁР. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 15 | **Зорилт 15** | 900.0 | Арга хэмжээний | Эко зуслангийн | Зураг төсвийг дуусгаж, | "Эко зуслан"-ийн загвар зураг, ажлын зураг, цахилгааны хангамжийн ажлын | 40% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Хүүхдийн зуслан, бичил цэцэрлэгт хүрээлэнгийн тоог нэмэгдүүлж, иргэдийн эрүүл аюулгүй хөгжлийн орчныг бүрдүүлэх бодлого баримтална. (НЗДҮАХ 5.1.1.1) | | хэрэгжилтийн хувь | зураг төсвийн ажлын 50 хувьтай | барилгын ажлыг эхлүүлнэ | зураг төсөл боловсруулж дууссан. Нийслэлийн Онцгой байдлын газартай зөвшилцөж байна. | |
| 15.1 | Арга хэмжээ: Дүүргийн 14 дүгээр хороонд залуу гэр бүлд зориулсан эко зуслангийн ажлыг эхлүүлнэ. | 900.0 | Зураг төсвийг дуусгаж, барилгын ажлыг эхлүүлсэн эсэх | Эко зуслангийн зураг төсвийн ажлын 50 хувьтай | Зураг төсвийг дуусгаж, барилгын ажлыг эхлүүлнэ | Дүүргийн төсвийн хөрөнгөөр 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 13.5 га газарт залуу гэр бүл амрах зориулалт бүхий “Эко зуслан"-ийн загвар зураг батлагдсан . Нийт 402 амины орон сууц, 14 ширхэг ариун цэврийн байгууламж, 5 тоглоомын талбай, 2 сагсан бөмбөгийн талбай, 300 авто машины зогсоол, 95000 м.кв ногоон байгууламж төлөвлөгдсөн. "Эко зуслан"-ийн цахилгааны хангамжийн ажлын зураг төслийг боловсруулж нийслэлийн Онцгой байдлын газартай зөвшилцөж байна. | 40% |
| 16 | **Зорилт 16**<br>Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, орон сууц, гэр хорооллын гэрэлтүүлгийг сайжруулж, нэгдсэн удирдлагын системд бүрэн холбоно. (НЗДҮАХ6.3.30) | 1,000.0 | Арга хэмжээний хэрэгжилтийн хувь | 2022 онд 420 ширхэг гэрэлтүүлэг суурилуулсан | Нийтийн эзэмшлийн талбайд 300-аас доошгүй гэрэлтүүлгийг суурилуулсан байна. | Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны 1.0 тэрбум хөрөнгөөр гэр хороолол, орон сууц хорооллд шинээр 360 ширхэг гэрэлтүүлэг шинээр суурилуулах ажлын зураг төслийг батлуулсан бөгөөд 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар гүйцэтгэгч шалгаруулах тендерийн үнэлгээ хийгдэж байна. | 40% |
| 16.1 | Арга хэмжээ: Дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, орон сууц, гэр хороололд 300-аас доошгүй гэрэлтүүлгийг шинээр суурилуулж, гэрэлтүүлгийн засвар, үйлчилгээг тогтмол хийж гүйцэтгэнэ. | 1,000.0 | Шинээр суурилуулсан гэрэлтүүлгийн тоо | 2022 онд 420 ширхэг гэрэлтүүлэг суурилуулсан | Нийтийн эзэмшлийн талбайд 300-аас доошгүй гэрэлтүүлгийг суурилуулсан байна. | Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар, Солонгос улсын “Дасан лайтинг” ХХК, дүүргийн нутаг дэвсгэрийн гэрэлтүүлэг хариуцсан “Новелнэтворк” ХХК нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, технологийн дэвшил бүхий нэгдсэн хяналт удирдлагын системийг нэвтрүүлж эрчим хүчний хэмнэлт бий болгох зорилгоор талууд зөвшилцөлд хүрч хамтын ажиллагааны гурван талт | 40% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | санамж бичгийг 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр байгуулсан.<br>Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны 1.0 тэрбум хөрөнгөөр гэр хороолол, орон сууц хороололд шинээр 360 ширхэг гэрэлтүүлэг шинээр суурилуулах ажлын зураг төслийг батлуулсан бөгөөд 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар гүйцэтгэгч шалгаруулах тендерийн үнэлгээ хийгдэж байна.<br>Орон сууцны хороолол, гэр хорооллын гэрэлтүүлгийн засвар, үйлчилгээг сайжруулж, тогтмол хяналт тавьж ажиллаж байна. Тус ажлын хүрээнд 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар 751 метр кабель шугам, 605 ширхэг гэрэл, 287 ширхэг 50 вт прожуктор, 87 ширхэг пускатель, 56 ширхэг 50 вт лед трансформатор, 42 ширхэг 70 вт лед трансформатор, 206 ширхэг гал хамгаалагч, 63 ширхэг цахилгааны самбарын хайрцгийг засварлаж, 62 ширхэг гэрэлтүүлгийн шонг сольж, шинэчилсэн.<br>Ажилчны гудамж, Үйлдвэрийн гудамж дагуу таггүй 35, Наадамчдын зам дагуу 85 гэрэлтүүлгийн шонг тагжуулж, ил гарсан 311 метр кабелийг цэгцэлж булж, орчны аюулгүй байдлыг хангасан.<br>Явган хүний зам голлосон гэрэлтүүлгийг шилжүүлэх ажил 2023 оны 04 дүгээр сарын 22-ны өдрөөс эхэлсэн бөгөөд Дунд голын гудамж дагуу 20 гэрэлтүүлгийн шонг шилжүүлж, явган хүний замын зорчих хэсгийг чөлөөлсөн.<br>Гэрэлтүүлгийн асалт өдрийн байдлаар 98.7 хувьтай байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 17 | **Зорилт 17** Гэр хорооллыг шинэ үзэл баримтлалын дагуу хөгжүүлж, иргэдэд боломжийн өртөгтэй орон сууцтай болох "Зөв шийдэлтэй" дахин төлөвлөлтийг системтэйгээр хийнэ. (НЗДҮАХ 6.1.7) | - | Арга хэмжээний хэрэгжилтийн хувь | 95 хувьтай хэрэгжсэн | 50% /Дахин төлөвлөлтөд холбогдох байгууллагад дэмжлэг үзүүлж ажиллана./ | Хан-Уул дүүргийн 4, 5, 6, 7, 8 дугаар хороодод нийт 10 хэсэг 314.75 га талбай буюу 5781 нэгж талбарт 9 төсөл хэрэгжүүлэгч гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах ажлыг үе шаттайгаар гүйцэтгэж байна. | 50% |
| 17.1 | Арга хэмжээ: Гэр хорооллын иргэдэд дахин төлөвлөлтийн талаар сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулж, иргэдийн хүсэлтийг холбогдох байгууллагуудад уламжлан хамтран ажиллана. | - | Зохион байгуулсан арга хэмээний тоо | 4 сургалт зохион байгуулсан | 5 /Сургалт, уулзалт зохион байгуулсан байна./ | "Яармагийн гэр хорооллын дахин төлөвлөлт"-ийн төслийн явцын талаарх мэдээллийг сар бүр шинэчилж, дүүргийн удирдлагууд болон, оршин суугч иргэдэд танилцуулсан.<br>Нийслэлийн Орон сууц бодлогын газартай хамтран 2023 оны 3 дугаар сарын 9-ний өдөр, 2023 оны 5 дугаар сарын 22-ны өдөр тус тус дүүргийн 4, 5, 6, 7, 8 дугаар хорооны 600 гаруй оршин суугч иргэдтэй гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн явцын талаарх мэдээлэл, санал асуулга, хэлэлцүүлэг уулзалтыг зохион байгуулсан. | 50% |
| 18 | **Зорилт 18** Ашиглалтын шаардлага хангахгүй байгаа нийтийн зориулалттай орон сууцнуудыг үе шаттайгаар шинэчилнэ. (НЗДҮАХ 6.1.9) | - | Арга хэмжээний хэрэгжилтийн хувь | 100 хувьтай хэрэгжсэн | 50% /Дахин төлөвлөлтөд холбогдох байгууллагад дэмжлэг үзүүлж ажиллана./ | Дүүргийн АШХНЗОС-ны 34 барилга байгаагаас 33 барилгад төсөл хэрэгжүүлэгч шалгарч, журмын дагуу буулган шинээр барих үйл ажиллагаа явагдаж байна. Одоогийн байдлаар 2339 айлын 11 орон сууц ашиглалтад оруулж, 816 айлыг эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлөөр хангасан. | 50% |
| 18.1 | Арга хэмжээ: Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг дахин төлөвлөхөд оршин суугчдаас санал авах ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна. | - | Ажлын явц, хувь | 100 хувьтай хэрэгжсэн | 100% /Тухай бүр санал авч, холбогдох байгууллагад хүргүүлнэ./ | "Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг дахин төлөвлөн барилгажуулах" төслийн явцын талаарх мэдээллийг сар бүр шинэчилж, дүүргийн удирдлагууд болон оршин суугч иргэдэд танилцуулсан.<br>Хот байгуулалт, хөгжлийн газартай хамтран 2023 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр, 5 дугаар сарын 9-ний өдөр тус тус | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | "Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг дахин төлөвлөн барилгажуулах" ажлын явцын талаар мэдээлэл өгөх, санал солилцох уулзалт хэлэлцүүлгийг 1,2,3 дугаар хорооны 500 гаруй оршин суугч иргэдийг оролцуулан зохион байгуулсан | |
| 19 | **Зорилт 19**<br>Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг хангуулж ажиллана. | - | Арга хэмжээний хэрэгжилтийн хувь | 91 хувьтай хэрэгжсэн | 90%-аас доошгүй хувьтай хэрэгжсэн байна. | 1. Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2023 оны төлөвлөгөөний 5 бүлэг, 9 зорилго, 22 зорилт, 47 арга хэмжээ хагас жилээр 48 хувь, хяналт-шинжилгээ, үнэлгээний 3 бүлэг, 7 зорилго, 16 зорилтын 36 шалгуур үзүүлэлт 68 хувь,<br>2. Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний 4 бүлэг, 15 зорилго, 16 зорилт, 81 арга хэмжээ хагас жилийн байдлаар 63,6 хувь,<br>3. Нийслэлийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 1 бүлэг, 3 зорилго, 3 зорилтын 3 арга хэмжээний биелэлт 47 хувь, хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт хагас жилийн байдлаар 50 хувьтай хэрэгжиж тайланг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох мэргэжилтэнрүү 2023 оны 06 дугаар сарын 07-нд цахимаар тус тус илгээсэн. | 30% |
| 19.1 | Арга хэмжээ: Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс Хан-Уул дүүрэг хамтран хэрэгжүүлэх заалтуудын биелэлтийг хангуулж, улирал тутам тайлагнаж ажиллана. | - | Хэрэгжилтийн хувь | 3 удаа тайлагнаж, жилийн эцсийн биелэлт 91 хувьтай хэрэгжсэн. | 90%-аас доошгүй хувьтай хэрэгжсэн байна. | Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2023 оны төлөвлөгөөний 5 бүлэг, 9 зорилго, 22 зорилт, 47 арга хэмжээ 1 дүгээр улиралд 38 хувь, хагас жилээр 48 хувь биелсэн. | 50% |
| 19.2 | Арга хэмжээ: Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнөөс Хан-Уул | - | | 3 удаа тайлагнаж, жилийн | 90%-аас доошгүй хувьтай | Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний 4 бүлэг, 15 зорилго, 16 зорилт, 81 арга хэмжээ 1 дүгээр улирлын | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дүүрэг хамтран хэрэгжүүлэх заалтуудын биелэлтийг хангуулж, улирал тутам тайлагнаж ажиллана. | | Хэрэгжилтийн хувь | эцсийн биелэлт 92 хувьтай хэрэгжсэн. | хэрэгжсэн байна. | байдлаар 35 хувьтай хэрэгжсэн бол хагас жилийн байдлаар 63,6 хувь биелсэн. | |
| 19.3 | Арга хэмжээ: Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрөөс тус дүүргийн хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн тайлан | - | Хагас бүтэн жилээр хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тоо | 2 удаа Хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, холбогдох албан тушаалтанд танилцуулж, тайлагнасан. | 2 удаа Хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, холбогдох албан тушаалтанд танилцуулж, тайлагнасан байна. | Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2023 оны төлөвлөгөөний батлагдсан Хяналт-шинжилгээ, үнэлгээний 3 бүлэг, 7 зорилго, 16 зорилтын 36 шалгуур үзүүлэлт 48 хувь, хагас жилээр 68 хувьтай. | 50% |
| 19.4 | Арга хэмжээ: Нийслэлийн хөгжлүүлэх таван жилийн үндсэн чиглэлээс Хан-Уул дүүрэг хамтран хэрэгжүүлэх заалтуудын биелэлтийг хангуулж, улирал тутам тайлагнаж ажиллана. | - | Хэрэгжилтийн хувь | 3 удаа тайлагнаж, жилийн эцсийн биелэлт 91 хувьтай хэрэгжсэн. | 90%-аас доошгүй хувьтай хэрэгжсэн байна. | Нийслэлийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 1 бүлэг, 3 зорилго, 3 зорилтын 3 арга хэмжээ хагас жилийн байдлаар 47 хувийн биелэлттэй. | 50% |
| 42.1 | Арга хэмжээ: Хог тээврийн болон зам цэвэрлэгээ, усалгааны авто машин худалдан авна. | 3,500.0 | Нийлүүлэгдсэн авто машины тоо | 2022 онд 13 хог-тээврийн авто машин, 2 зам цэвэрлэгээ усалгааны | 8-аас хог тээврийн авто машин, 3-аас доошгүй зам цэвэрлэгээ усалгааны | Хог тээврийн авто машины парк шинэчлэлтийн хүрээнд он дамжин хэрэгжсэн хог шахаж ачих зориулалтын Хьюндай HD78, HD170 маркийн 11 автомашиныг 2023 оны 1 дүгээр сард хог | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | авто машинаар парк шинэчлэлт хийгдсэн. | авто машинаар парк шинэчлэлт хийнэ. | тээврийн байгууллагуудад хүлээлгэж өгсөн.<br>Дүүргийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 12-ны 13 дугаар хурлын шийдвэрээр дүүргийн төсвийн 1.2 тэрбум төгрөгөөр хог тээврийн машины парк шинэчлэлт хийх төсөл арга хэмжээ цуцлагдсан.<br>Дүүргийн төсвийн 800.0 сая төгрөгийн хөрөнгөөр 5 ширхэг задгай тэвштэй хог тээврийн машин худалдаж авах ажил гүйцэтгэгч шалгаруулах шатанд хэрэгжиж байна. | |
| 43 | **Зорилт 43**<br>Засаг даргаас бүрэн эрх, бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулж ажиллана. | - | Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, хувь | 91 хувьтай хэрэгжсэн | 90%-аас доошгүй хувьтай хэрэгжсэн байна. | Дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх "Эко-Эрүүл дүүрэг" үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 бүлэг, 23 зорилго, 108 зорилт, 151 арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө эхний улиралд 31%-тай хэрэгжсэн. | 30% |
| 43.1 | Арга хэмжээ: Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх "Эко-Эрүүл дүүрэг" үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг хангуулж хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллана. | - | Хэрэгжилт, хувь | 2 удаа тайлагнаж, жилийн эцсийн биелэлт 91 хувьтай хэрэгжсэн. | 90%-аас доошгүй хувьтай хэрэгжсэн байна. | Хагас жилийн биелэлтийг нэгтгэхээр Засаг даргын Тамгын газрын даргын 2023.05.03-ны 03/731 тоот албан бичгийг дэргэдэх 28 байгууллагуудад хүргүүлсэн бөгөөд биелэлт нэгтгэгдэж байна. | 50% |
| 43.2 | Арга хэмжээ: Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын дарга нартай Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх "Эко-Эрүүл дүүрэг" үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хариуцлагын гэрээг байгуулах, дүгнэх ажлыг зохион байгуулна. | - | Гэрээ байгуулж, дүгнэсэн эсэх | 27 дэргэдэх хэлтэс, албадын дарга нартай хариуцлагын гэрээ байгуусан. | Гэрээ байгуулж, дүгнэсэн байна. | Хан-Уул дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын дарга нартай Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх "Эко-Эрүүл дүүрэг" үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны хариуцлагын гэрээг байгуулсан. | 30% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 43.3 | Арга хэмжээ: Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн тайлан | - | Хагас бүтэн жилээр хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тоо | 2 удаа Хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, холбогдох албан тушаалтанд танилцуулж, тайлагнасан. | 2 удаа Хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, холбогдох албан тушаалтанд танилцуулж, тайлагнасан байна. | Дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх "Эко-Эрүүл дүүрэг" үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 бүлэг, 23 зорилго, 108 зорилт, 151 арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө 1 дүгээр улиралд 30 хувь, хагас жилийн байдлаар 40 хувь, хяналт шинжилгээ үнэлгээний 5 бүлэг, 23 зорилго, 106 зорилт, 164 шалгуур үзүүлэлт 54 хувьтай хэрэгжээд байна. | 50% |
| 44 | **Зорилт 44**<br>Засаг даргаас бүрэн эрх, бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дүүрэг хороо, Засаг даргын дэргэдэх хэлтэс, алба, байгууллагуудын үйл ажиллагааг төвлөрүүлэх, хяналт тавих, шаардлагатай бүх төрлийн мэдээллийг боловсруулан дүгнэлт, санал бэлтгэх ажлыг зохион байгуулж Засаг даргыг мэдээллээр хангаж, ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ. | 35,0 | Арга хэмжээний хэрэгжилтийн хувь | 1 удаа Хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, холбогдох албан тушаалтанд танилцуулж, тайлагнасан. | Хяналт, шинжилгээ үнэлгээг төлөвлөсний дагуу зохион байгуулж, холбогдох албан тушаалтанд танилцуулж, тайлагнасан байна. | Дээд шатны байгууллага, албан тушаалтныг шаардлагатай мэдээллээр хангаж, дүүрэгт хэрэгжиж буй бодлого, дүүргийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны үр дүнг сайжруулах зорилгоор 13 арга хэмжээ бүхий Хяналт шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө боловсруулж, Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулан эхний хагас жилийн байдлаар 51 хувьтай хэрэгжүүлээд байна. Тухайлбал 2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагаа, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын 5 зөвлөмжийг давхардсан тоогоор дүүргийн Засаг даргын харьяа 60 байгууллагад Тамгын газрын 2023 оны 06/82, 06/382-388, 06/571 тоот албан бичгээр хүргүүлж, биелэлтийг тооцон ажиллаж байна. | 30% |
| 44.1 | Арга хэмжээ: Дүүргийн засаг захиргааны нэгж, харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд явцын болон гүйцэтгэлийн хяналт, шинжилгээ үнэлгээг батлагдсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу зохион байгуулах | 10,0 | Хяналт шинжилгээ, үнэлгээний тоо | 1 удаа Хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, холбогдох албан тушаалтанд танилцуулж, | 2 удаа Хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, холбогдох албан тушаалтанд танилцуулж, | Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон өргөдөл гомдол шийдвэрлэлтийн зөрчлийг бууруулах арга хэмжээний хэрэгжилтийн явцад хийх хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын удирдамжийг 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулж, хуварийн дагуу | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | тайлагнасан байна. | тайлагнасан байна. | Хяналт шинжилгээ, үнэлгээний ажлыг зохион байгуулсан. | |
| 44.2 | Арга хэмжээ: Дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх Эко-эрүүл дүүрэг үйл ажиллагааны хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийлгэнэ. | 25.0 | Хяналт шинжилгээ, үнэлгээ хийлгэсэн эсэх | - | 1 удаа Хөндлөнгийн үнэлгээг журмын дагуу хийлгэсэн байна. | Хугацаа болоогүй | - |
| 45 | **Зорилт 45** Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд мод тарих, ногоон байгууламж байгуулахыг дэмжих, "Эко ногоон дүүрэг" дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ. (ДЗДҮАХ 1.1.3) | - | Хөтөлбөрийн хэрэгжилт, хувь | 30% /Хөтөлбөрийн хэрэгжилт 30 хувьд хүрсэн./ | 70% /Хөтөлбөрийн хэрэгжилтийг 70 хувьд хүргэнэ/ | Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/70 дугаар захирамжаар "Эко ногоон дүүрэг" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх салбар зөвлөлийг шинэчлэн байгуулсан.<br>Дэд хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлсэн 4 зорилт 17 арга хэмжээ 2023 оны 02 дугаар улирлын байдлаар 80 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. | 60% |
| 45.1 | Арга хэмжээ: "Бүх нийтээр мод тарих" үндэсний өдөр арга хэмжээг зохион байгуулж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллана. | 50.0 /ДТХО/ | Зохион байгуулсан арга хэмжээ, тоо | "Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр" арга хэмжээг 2 удаа зохион байгуулсан. | "Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр" арга хэмжээг 2 удаа зохион байгуулна. | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд Хан-Уул дүүрэгт 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний календарчилсан төлөвлөгөө, "Ногоон хот – Иргэний оролцоо" мод тарих аяныг зохион байгуулах ажлын төлөвлөгөө, хуваарийг боловсруулан батлуулж, хэрэгжүүлж ажилласан.<br>Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны А/147 дугаар захирамжийн дагуу "Ногоон хот – Иргэний оролцоо" мод тарих аяныг 2023 оны 05 дугаар сарын 13-ны өдрөөс 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдөр хүртэл хугацаанд зохион байгуулж, шинээр 25958 ширхэг, нөхөн тарилтаар 575 ширхэг мод, бут, сөөгийг тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн. | 50% |
| | | | Тарьсан мод, бутны тоо | 85028 ширхэг мод, бут, сөөг тарьсан. | 20,000 ширхэгээс багагүй мод, бут, сөөг тарьна. | | |
| 45.2 | Арга хэмжээ: Мод үржүүлгийн газар байгуулах зураг төсөл, техник эдийн засгийн үндэслэлийг батлуулж, үржүүлгийн | 48.9 /ДТХО/ | Ажлын явц, хувь | 30% /зураг төсөл, техник эдийн засгийн үндэслэл | 100% /Зураг төслийг батлуулж, мод үржүүлгийн | Мод үржүүлгийн газар байгуулах ажлын зураг төсөл, техник эдийн засгийн үндэслэлийг "Тоонто гранд" ХХК гүйцэтгэж, захиалагчтай загвар зураг, ажлын зургийг зөвшилцөж батлуулсан. | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | газрын үйл ажиллагаа эхлүүлнэ. | | | боловсруулагдсан/ | газрын үйл ажиллагаа эхлүүлнэ./ | Тус зураг төсөл магадлалын шатанд, дүүргийн Засаг даргаар олгогдсон байсан газар эзэмших эрхийг нийслэлийн Засаг даргын захирамжаар батлуулах шаардлагаар буцаж, Нийслэлийн газар зохион байгуулалтын албанд 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдөр хүсэлт гаргаж, нийслэлийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/380 дугаар захирамжаар Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газарт газар эзэмших эрхийг олгосон. Хот байгуулалт, хөгжлийн газарт 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 03/882 дугаартай албан бичгээр архитектур төлөвлөлтийн даалгаврыг шинэчлэх хүсэлт гаргасан. Архитектур төлөвлөлтийн даалгавар гарсаны дараа зураг төсөлд өөрчлөлт оруулж, дахин магадлал хийлгэнэ. Нийтийн эзэмшлийн гудамж талбайн хэлбэржүүлэлтээс гарсан улиасны мөчрөөр харандаа бэлтгэж, үржүүлэх ажлыг 2023 оны 05 дугаар сарын 06-ны өдрөөс эхлүүлж, 05 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар 6500 ширхэг улиасны харандааг Агропаркийн талбайд тарьсан. | |
| 45.3 | Арга хэмжээ: Мод үржүүлгийн газар болон мод, бут сөөг тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд ашиглагдах техник, тоног төхөөрөмжийг сайжруулна. | 215.0 /ДТХО/ | Шинээр худалдаж авсан трактор, тоног төхөөрөмжийн тоо | Модны нүх ухагч 1 өрөм худалдаж авсан. | 2-оос доошгүй дунд оврын трактор, механизм худалдаж авна. | Ногоон байгууламжийн тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд дүүргийн төсвийн 215.0 сая төгрөгийн хөрөнгөөр 2 ширхэг бага оврын трактор, механизм нийлүүлэх гүйцэтгэгчээр "Монтех дистр-ибьюшн" ХХК шалгарч, 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр гэрээ байгуулсан. | 60% |
| 45.4 | Арга хэмжээ: Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажилд иргэд аж | - | Зохион байгуулсан | "Манай хороо – Миний | Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагууд | Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2023 оны А/24 дүгээр тушаал, Хан-Уул дүүргийн Засаг даргын | 40% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ахуйн нэгж, байгууллагуудыг идэвхжүүлэх, татан оролцуулах болзолт аян, уралдааныг зохион байгуулна. | | арга хэмжээ, тоо | гудамж" аяныг зохион байгуулсан. | ын оролцоотой тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх 1 аян зохион байгуулна. | 2023 оны А/105 дугаар захирамжаар дүүргийн нутаг дэвсгэрт "Манай хороо – Миний гудамж" аяныг зохион байгуулах, шалгаруулах үүрэг бүхий дэд ажлын хэсэг байгуулж, төлөвлөгөө удирдамжийг батлан, ажиллаж байна. Аяны хүрээнд 2, 3, 4 дүгээр сард зохион байгуулсан ажлын тайланг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хүргүүлсэн. Аяны хүрээнд 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар 1, 20 дугаар хорооны 2 сууц өмчлөгчдийн холбоо, 2 аж ахуйн нэгж, байгууллага өөрсдийн эзэмшлийн болон нийтийн эзэмшлийн гудамж талбайг зүлэгжүүлж тохижуулах ажлыг хэрэгжүүлж байна.<br>"Ногоон хот – Иргэний оролцоо" мод тарих аяны хүрээнд 9, 10, 12, 13, 14, 16 дугаар хорооны 1050 өрхтэй хамтарч жимсний болон гоёлын 10,500 ширхэг мод, бут, сөөгийг тарьсан. | |
| 45.5 | Арга хэмжээ: Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Айцын аманд ойжуулах, ойн зурвас байгуулах ажлыг үргэлжлүүлнэ. | 500.0 /ДТХО | Ойжуулалт хийсэн талбай, га | 2022 онд 8 га талбайд 7883 ширхэг мод, бут тарьсан. | 5 га -аас багагүй талбайд мод, бут, тарьж, ойжуулалтын талбайн хэмжээг нэмэгдүүлнэ. | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд Хан-Уул дүүргийн 14 дүгээр хороо, Айцын аманд 2022 онд мод тарьсан 8 га талбайн цэнэг усалгаа, арчлалт болон бүх нийтээр мод тарих үндэсний өдрийн бэлтгэл ажлыг 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлүүлж, ажлын явц, үр дүн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлогын зөвлөх Н.Батхүүгээр ахлуулсан ажлын хэсэгт танилцуулсан.<br>"Ногоон хот – Иргэний оролцоо" мод тарих өдөрлөгийг зохион байгуулах, бэлтгэл ажлыг бүрэн хангаж, 2023 оны 05 дугаар сарын 13, 14-ний өдрүүдэд Айцын аманд хэрэгжүүлж буй ойн төгөл байгуулах талбайн А хэсэгт Хан-Уул | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дүүргийн Засаг даргын Тамгын газар, хороодын Засаг дарга нар, Соёлын ордон, хэвлэл мэдээллийн байгууллагуудын төлөөлөл, Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ, нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд болон нийслэлийн төсөв 16 байгууллагын нийт 393 ажилтан албан хаагчид шинээр 630 ширхэг, нөхөн тарилтаар 85 ширхэг мод тарьж, 2022 онд тарьсан мод, бутыг усалж, арчлалт хамгаалалтыг хийсэн. Айцын аманд хэрэгжүүлж буй ойн төгөл байгуулах талбайн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор 2023 оны 05 дугаар сарын 15-23-ны өдөр хүртэл хугацаанд 60 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж, батлагдсан зураг төслийн дагуу "В" хэсгийн 3.5 га талбайд 740 урт метр хамгаалалтын хашаа барьж, 1100 нүх ухаж, 1 гүний худаг өрөмдөж, тус талбайд шинээр 8328 ширхэг мод, бут, сөөгийг тарьж, төгөл байгуулсан.Тус талбайн арчлалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-ын дэргэд нэмэлтээр нийт 20 хүний бүрэлдэхүүнтэй 2 иргэдийн бүлгийг байгуулан ажиллаж байна. | |
| 45.6 | Арга хэмжээ: Гоёл чимэглэлийн цэцгийн үрсэлгээг хийх, нийтийн эзэмшлийн гудамж, талбайд цэцгийн мандал байгуулж, хотын өнгө үзэмжийг нэмэгдүүлнэ. | 150.0 /ДТХО/ | Үрслүүлсэн цэцэг, тоо | 267,519 ширхэг | 300,000 ширхэгээс багагүй гоёл, чимэглэлийн цэцэг үрслүүлнэ. | Дүүргийн Засаг даргын 2023 оны А/74 дүгээр захирамжийн дагуу гоёл чимэглэлийн 400,000 цэцгийг үрслүүлж, бойжуулах ажлыг 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрөөс эхлүүлэн, хяналт тавьж ажиллаж байна. Цэцгийн үрсэлгээний ажил хэвийн үргэлжилж байна. | 50% |
| | | | Мандал байгуулсан талбай, м.кв | 2805 м.кв | 3000 м.кв-аас багагүй талбайд цэцгийн | Дүүргийн 1, 2, 6, 8, 11, 12, 13, 14, 15, 16, 20, 21, 22 дугаар хороодын нийтийн эзэмшлийн гудамж, талбайн 26 байршлын нийт 3823 м.кв талбайд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мандал байгуулж, усалгаа, арчлалт хамгаалалтыг сайжруулна. | цэцгийн мандал байгуулахаар төлөвлөсөн бөгөөд цаг агаарын нөхцөлөөс шалтгаалан 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн мандал байгуулах ажил хэрэгжинэ. | |
| 45.7 | Арга хэмжээ: Мэргэжлийн байгууллагуудтай хамтарч мод тарьж ургуулах, арчлах хамгаалах талаар мэдлэг, мэдээлэл олгох чиглэлээр онол, практикт суурилсан сургалт зохион байгуулна. | 50.0 /ДТХО/ | Зохион байгуулсан арга хэмжээ, тоо | 2 удаагийн сургалт зохион байгуулсан. | 10-аас доошгүй сургалт, сурталчилгааны ажлыг цахим, танхим, үйлдвэрлэл сургалт хэлбэрээр зохион байгуулсан байна. | "Ногоон хот – Иргэний оролцоо" мод тарих аяны хүрээнд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудыг мод тарих, арчлах хамгаалахыг уриалсан постер, мэдээллийг бэлтгэж дүүрэг, хороодын цахим хаягаар сурталчилж ажилласан.<br>Мод тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжиж буй ажлын мэдээллийг бэлтгэж, хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдээр сурталчлах арга хэмжээ авсан. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас зохион байгуулсан сургагч багш бэлтгэх сургалтад дүүргээс 2 иргэнийг хамруулсан.<br>Гэр хороололд мод тарих ажлын хүрээнд мод тарих, арчлах хамгаалах хялбаршуулсан, аргачлал бүхий 1050 гарын авлагыг бэлтгэж, айл өрхүүдэд өгсөн. | 30% |
| 46 | **Зорилт 46**<br>Дүүргийн гэрэлтүүлэг, зам талбай, хайс хашаа, барилгын түр хашаа болон бусад тохижилтын ажлуудад хотын стандарт, жишгийг мөрдүүлнэ.<br>(ДЗДҮАХ 5.1.4) | - | Арга хэмжээний биелэлт, хувь | 100% /3 арга хэмжээ 100 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн./ | Гарсан зөрчлийн 50-аас доошгүй хувьд стандарт хангуулж ажиллана. | Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/242 дугаар захирамжаар батлагдсан иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилтын хүрээнд хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах нэгдсэн арга хэмжээний удирдамж, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хяналт тавих, тайлагнах үүрэг бүхий 55 хүний бүрэлдэхүүнтэй 5 дэд ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Тус ажил 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдөр хүртэл хэрэгжинэ. | 40% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 46.1 | Арга хэмжээ: Эвдрэлтэй авто замыг нөхөж, засварлах, гэр хорооллын гудамж талбайг хусаж, дайргаар засварлах, зорчих хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажиллана. | 170.0 /ДТХО/ | Нөхсөн талбай, м.кв | Эвдрэлтэй авто замын 8468 м.кв талбайг нөхөж, засварласан. | 2000 м.кв-аас багагүй талбайг нөхөж засварлана. | Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр дүүргийн хэмжээнд 29 гол болон туслах гудамжны 14686 м.кв талбайд авто замыг нөхөж засварлах ажил хэрэгжихээр төлөвлөгдсөн бөгөөд 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар 70 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Дүүргийн авто замын засвар, шинэчлэлтийн ажлын хүрээнд Хан-Уул зам засвар, арчлалт ОНӨААТҮГ дүүргийн 9, 10, 12, 19, 20 дугаар хороонд шинээр 2.2 км хатуу хучилттай авто зам тавих, эвдрэлтэй 2000 м.кв авто зам нөхөх, орон сууц хороололд 900-1000 м.кв талбай бүхий авто зогсоол байгуулах, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 12, 13, 14, 16 дугаар хороодын гэр хорооллын 120,000 м.кв талбай бүхий гудамж, талбайг хусаж, дайргаар засварлах ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөж, бэлтгэл хангаж ажиллаж байна. | 40% |
| | | 1,600.0 /ДТХО/ | Хусаж тэгшилсэн гудамж, тоо | Гэр хорооллын 58 гудамж талбайг хусаж, дайргаар засварлах арга хэмжээ авч ажиллана. | 50-иас доошгүй гудамж, талбайг хусаж тэгшлэх, дайргаар засварлах арга хэмжээ авна. | Дүүргийн авто замын засвар, шинэчлэлтийн ажлын хүрээнд 4, 5, 6, 7, 8, 9, 10, 12, 13, 14, 16 дугаар хороодын гэр хорооллын 120,000 м.кв талбай бүхий гудамж, талбайг хусаж, дайргаар засварлах ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 1 дүгээр ээлжийн 50,000 м.кв талбайг хусаж засварлах ажлын захирамж батлагдах шатанд хэрэгжиж байна. | 30% |
| 46.2 | Арга хэмжээ: Орон сууцны хороолол, гэр хорооллын гэрэлтүүлгийн засвар, үйлчилгээг сайжруулж, тогтмол хяналт тавьж ажиллана. | 714.4 /ДТХО/ | Засвар үйлчилгээг хариуцах гэрэлтүүлэг, тоо | Орон сууц, гэр хорооллын 6251 ширхэг гэрэлтүүлгийн ашиглалтын хэвийн үйл ажиллагааг | Орон сууц, гэр хорооллын 6713 ширхэг гэрэлтүүлгийн ашиглалтын хэвийн үйл ажиллагааг хангаж, засвар | Орон сууцны хороолол, гэр хорооллын гэрэлтүүлгийн засвар, үйлчилгээг сайжруулж, тогтмол хяналт тавьж ажиллаж байна.<br>Тус ажлын хүрээнд 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар 751 метр кабель шугам, 605 ширхэг гэрэл, 287 ширхэг 50 вт прожуктор, 87 ширхэг пускатель, 56 ширхэг 50 вт лед | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хангаж ажилласан. | үйлчилгээг тогтмол хийнэ. | трансформатор, 42 ширхэг 70 вт лед трансформатор, 206 ширхэг гал хамгаалагч, 63 ширхэг цахилгааны самбарын хайрцгийг засварлаж, 62 ширхэг гэрэлтүүлгийн шон сольж, шинэчилсэн. Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд Ажилчны гудамж, Үйлдвэрийн гудамж дагуу таггүй 35, Наадамчдын зам дагуу 85 гэрэлтүүлгийн шонгийн тагжуулж, ил гарсан 311 метр кабелийг цэгцэлж булж, орчны аюулгүй байдлыг хангасан.<br>Явган хүний зам голлосон гэрэлтүүлгийг шилжүүлэх ажил 2023 оны 04 дүгээр сарын 22-ны өдрөөс эхэлсэн бөгөөд Дунд голын гудамж дагуу 20 гэрэлтүүлгийн шонг шилжүүлж, явган хүний замын зорчих хэсгийг чөлөөлсөн.<br>Гэрэлтүүлгийн асалт өдрийн байдлаар 98.7 хувьтай байна. | |
| 46.3 | Арга хэмжээ: Төсвийн хөрөнгөөр суурилуулсан камерын засвар, үйлчилгээг сайжруулж, ашиглалтын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллана. | 690.0 /ДТХО/ | Засвар үйлчилгээг хариуцах камер, тоо | 991 ширхэг камерын ашиглалтын хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан. | 2774 ширхэг камерын ашиглалтын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллана. | Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны А/93 дугаар захирамжаар төсвийн хөрөнгө оруулалтаар 141 байршилд нийт суурилуулсан 1232 ширхэг хяналтын камерыг бүх төрлийн ашиглалт, засвар үйлчилгээг "Нийтлэг үйлчилгээний алба" ОНӨААТҮГ-т хариуцуулан ажиллаж байна. Тус ажлын хүрээнд 159 камерын ашиглалтын хугацаа дуусаж, солих шаардлагатай болсон бөгөөд 79 хяналтын камерт ээлжит засвар үйлчилгээ хийсэн. Нийт 994 хяналтын камер бүрэн ажиллаж байна. | 50% |
| 47 | **Зорилт 47**<br>Сул шороон хөрсийг зүлэгжүүлж, хатуу хучилттай болгон тоосжилтыг бууруулж, иргэдэд ээлтэй | - | Зүлэгжүүлсэн талбай, м.кв | Тохижилт бүтээн байгуулалтын ажлын хүрээнд 1, 2, 3, 4, 8, 11, | 15,000 м.кв-аас багагүй талбайг зүлэгжүүлнэ. | Цаг агаарын нөхцөл байдлаас хамааран тохижилт бүтээн байгуулалтын ажлын хүрээнд хэрэгжих зүлэгжүүлэлтийн ажил 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс хойш хэрэгжихээр байна. | 10% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | орчныг бүрдүүлнэ. (ДЗДҮАХ 5.3.5) | | | 12, 15, 16, 19, 20, 21, 22 дугаар хороонд 46341.2 м.кв сул шороон хөрс бүхий талбайг шинээр зүлэгжүүлсэн. | | “Манай хороо – Миний гудамж” аяны хүрээнд 1, 20 дугаар хорооны 2 сууц өмчлөгчдийн холбоо 39 дүгээр байр, Цагаан орд хотхоны гадна нийтийн эзэмшлийн гудамж талбайг тохижуулж, зүлэгжүүлэхээр бэлтгэл хөрс дэвсэж байна. | |
| 47.1 | Арга хэмжээ: Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн сул шороон хөрсийг зүлэгжүүлж, тоосжилтыг бууруулах арга хэмжээ авч ажиллана. | - | Зүлэгжүүлсэн талбай, м.кв | Тохижилт бүтээн байгуулалтын ажлын хүрээнд 1, 2, 3, 4, 8, 11, 12, 15, 16, 19, 20, 21, 22 дугаар хороонд 46341.2 м.кв сул шороон хөрс бүхий талбайг шинээр зүлэгжүүлсэн. | 15,000 м.кв-аас багагүй талбайг зүлэгжүүлнэ. | Цаг агаарын нөхцөл байдлаас хамааран тохижилт бүтээн байгуулалтын ажлын хүрээнд хэрэгжих зүлэгжүүлэлтийн ажил 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс хойш хэрэгжихээр байна.<br>“Манай хороо – Миний гудамж” аяны хүрээнд 1, 20 дугаар хорооны 2 сууц өмчлөгчдийн холбоо 39 дүгээр байр, Цагаан орд хотхоны гадна нийтийн эзэмшлийн гудамж талбайг тохижуулж, зүлэгжүүлэхээр бэлтгэл хөрс дэвсэж байна. | 10% |
| 48 | **Зорилт 48**<br>Хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр “Хоггүй Хан-Уул” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. (ДЗДҮАХ 5.4.1) | 1,971.6 /ДТХО/ | Хөтөлбөрийн хэрэгжилт, хувь | 50% /Хөтөлбөрийн хэрэгжилт 50 хувьд хүрсэн./ | 75% /Хөтөлбөрийн хэрэгжилтийг 75 хувьд хүргэнэ/ | Дүүргийн Засаг даргын 2023 оны А/70 дугаар захирамжаар "Хоггүй Хан-Уул" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх Салбар зөвлөлийг шинэчлэн баталсан. “Хог хаягдал, цуглуулах, тээвэрлэх гэрээ”-ний загварыг шинэчилж, дүүргийн Засаг даргын 2022 оны А/647 дугаар захирамжийн дагуу аж ахуйн нэгж байгууллагуудтай хог тээврийн гэрээ байгуулах ажлыг хариуцаж байгаа бөгөөд нийт 537 гэрээг шинээр болон шинэчилж байгуулсан. Тус ажлын | 30% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүрээнд 450 аж ахуй нэгж, байгууллагын тохижилт, цэвэрлэгээг хариуцах орчны 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газрын зураглалыг гэрээний хавсралтаар баталгаажуулж, Газарзүй мэдээллийн системд (ArcGIS) бүртгэсэн. Аж ахуй нэгж, байгууллагуудын хог хаягдал цуглуулах, тээвэрлэх гэрээний дагуу төлбөр төлөлтийг эрчимжүүлэх, хяналт тавих зорилгоор дүүргийн Засаг даргын Тамгын газар, Татварын хэлтэс, хог тээврийн байгууллагууд, хороодын дундын мэдээллийн санг (Google sheet) үүсгэн 7 хоног бүр мэдээллийг шинэчлэн ажиллаж байгаа бөгөөд 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 537 байгууллагын мэдээлэл бүртгэгдсэн. | |
| 48.1 | Арга хэмжээ: Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээг сайжруулж, авто зам, явган хүний замын цас, мөсийг цэвэрлэх, халтиргаа гулгаанаас сэргийлэх арга хэмжээ авч ажиллана. | 1,931.6 /ДТХО/ | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100% / орон сууц, гэр хорооллын авто зам, явган хүний замын хог хаягдал, цас мөсийг тогтмол цэвэрлэж, халтиргаа, гулгаанаас сэргийлэх арга хэмжээ авч ажилласан/ | 100% /орон сууц, гэр хорооллын авто зам, явган хүний замын хог хаягдал, цас мөсийг тогтмол цэвэрлэж, халтиргаа, гулгаанаас сэргийлэх арга хэмжээ авч ажиллана./ | Дүүргийн авто зам, явган замын цэвэрлэгээ, үйлчилгээг шинээр хариуцаж буй 8 байгууллага болох Хот тохижилтын газар ОНӨААТҮГ, "Чингэлтэй ТҮК" ХХК "Охь мандал" ХХК, "Эко эрин тохижилт" ХХК, "Экспресс зам" ХХК, "ТЖН Форестри" ХХК, "Гранд зевс" ХХК-ийн хариуцсан 18 байршлын төв зам, "Тохижилт үйлчилгээний төв" ОНӨААТҮГ-ын хариуцсан 102 туслах замын цэвэрлэгээ үйлчилгээнд тогтмол хяналт тавин ажиллаж байна. Тус ажлын хүрээнд халтиргаа гулгааг арилгах чиглэлээр 3 удаагийн бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж, нийт 18 тонн цас мөсийг цэвэрлэн, халтиргаа гулгаанаас сэргийлэн ажилласан. Авто замын цас мөсийг цэвэрлэх, халтиргаа гулгааг арилгах зорилгоор 2023 онд 174.5 тн давс, 14 тн бодис цацсан байна. | 50% |
| 48.2 | Арга хэмжээ: "Хоггүй Хан-Уул 2023" аяны хүрээнд бүх нийтийн их цэвэрлэгээг | 40.0 /ДТХО/ | Зохион байгуулсан их | Бүх нийтийн их цэвэрлэгээг | Бүх нийтийн их цэвэрлэгээг | Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/54 дүгээр захирамжаар "Хоггүй Хан-Уул | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулж, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудыг татан оролцуулна. | | цэвэрлэгээ, тоо | 12 удаа зохион байгуулж, 1,265.2 тн хог хаягдлыг цэвэрлэсэн. | 10-аас доошгүй удаа зохион байгуулж, хог хаягдлыг бууруулна. | 2023" аяны хүрээнд 12 удаагийн бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулахаар баталсан бөгөөд дүүргийн хэмжээнд 7 удаагийн бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж, Засаг даргын Тамгын газар, дэргэдэх хэлтэс, албад болон дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг нийт 7947 аж ахуй нэгж байгууллага, 308 сууц өмчлөгчдийн холбоодын 12,450 хүн оролцож, 715,311 м.кв талбайгаас 368,7 тонн хог хаягдлыг цэвэрлэсэн.<br>Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргаар 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдөр дүүргийн хэмжээнд "Хаврын их цэвэрлэгээ" сарын аян зохион байгуулах удирдамжийг батлуулж, аяны хүрээнд 115 автобусны буудал, 2,850 урт метр хайс хашлага, 205 авто замын тэмдэг тэмдэглэгээ, 26 хөшөө дурсгал, 455 спорт болон тоглоомын талбай, 226 хогийн сав, 210 сандлыг тус тус угааж цэвэрлэсэн, гэрэлтүүлгийн 25 шон дээр наасан 32 зарыг хуулж арилгасан. Удирдамжийн дагуу үргэлжлүүлэн гадна сурталчилгааны самбар, фасад угааж цэвэрлэх ажлыг зохион байгуулж байна. | |
| 48.3 | Арга хэмжээ: Бохирдол ихтэй нийтийн эзэмшлийн гудамж, талбай, гэр хорооллын нүхэн жорлон, бохирын цооногийг ариутгаж, халдваргүйлэх, хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээ авч ажиллана. | 150.0 /ДТХО/ | Ариутгаж халдваргүй-жүүлсэн талбайн хэмжээ, м.кв | Бохирдол ихтэй 158,200 м.кв талбайг ариутгаж халдвар-гүйжүүлсэн. | 300,000 м.кв-аас багагүй талбайг ариутгаж, халдваргүйжүүлнэ. | Дүүргийн Засаг даргын 2023 оны А/286 дугаар захирамжийн дагуу 8, 10, 12, 13, 14, 21 дүгээр хороодын нутаг дэвсгэрт үхсэн мал амьтны сэг зэм, өтөг бууцыг цэвэрлэж, ариутгаж халдваргүйжүүлсэн. Дүүргийн 5, 22 дугаар хорооны нутаг дэвсгэрт бохир хальсан болон хогийн цэгийн 15,000м.кв. талбайг ариутгаж, халдваргүйжүүлсэн. Дүүргийн Засаг даргын 2023 оны А/196 дугаар захирамжийн дагуу дүүргийн гэр хорооллын айл өрхийн 12,099 нүхэн | 50% |
| | | 86.0 /ДТХО/ | Ариутгаж халдваргүй-жүүлсэн нүхэн жорлон бохирын | Гэр хорооллын 16196 ширхэг нүхэн жорлон, | 13855 нүхэн жорлон, 8340 бохирын цооногийг ариутгаж | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | цооногийн тоо | бохирын цооногийг ариутгаж халдвар-гүйжүүлсэн. | халдваргүйжүүлнэ. | жорлон, 5732 бохирын цооногийг ариутгаж халдваргүйжүүлэх ажил гүйцэтгэгч шалгаруулах шатанд хэрэгжиж байна. | |
| 49 | **Зорилт 49**<br>Аж ахуйн нэгж байгууллагуудыг хаягдал усаа цэвэршүүлэн дахин ашиглах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. /ДЗДҮАХ 5.6.1/ | - | Зөвшөөрөл олгосон аж ахуйн нэгж байгууллагын тоо | Холбогдох шатны байгууллагын дүгнэлтийг үндэслэн 7 ААНБ-д ус ашиглах, 7 ААНБ-д ус хаях зөвшөөрөл олгож, 1 ААНБ-ын ус хаях цэг тогтоосон. | Ус ашиглах болон хаягдал усны дүгнэлтийг үндэслэн зөвшөөрөл олгоно. | Туул голын сав газраас ирүүлсэн дүгнэлтийг үндэслэн 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/48 дугаар захирамжаар "Эко асфальт" ХХК-д хаягдал ус хаях зөвшөөрөл олгож, 3 аж ахуйн нэгжид хаягдал ус хаях зөвшөөрөл олгох захирамжийн төсөл хянагдаж байна. Нийслэлийн Байгаль орчны газраас ирүүлсэн "Ус ашиглуулах дүгнэлт"-ийг үндэслэн 1 аж ахуй нэгжид дүүргийн Засаг даргын захирамжаар ус ашиглах зөвшөөрөл олгохоор захирамжийн төсөл боловсруулагдсан хянах шатанд байна. | 50% |
| 49.1 | Арга хэмжээ: Холбогдох шатны байгууллагын дүгнэлтийг үндэслэн "Ус ашиглах зөвшөөрөл", "Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл" олгох гэрээ байгуулж, хяналт тавьж, усны мэдээллийн санд бүртгэнэ. | - | Зөвшөөрөл олгосон аж ахуйн нэгж байгууллагын тоо | Холбогдох шатны байгууллагын дүгнэлтийг үндэслэн 7 ААНБ-д ус ашиглах, 7 ААНБ-д ус хаях зөвшөөрөл олгож, 1 ААНБ-ын ус хаях цэг тогтоосон. | Ус ашиглах болон хаягдал усны дүгнэлтийг үндэслэн зөвшөөрөл олгоно. | Туул голын сав газраас ирүүлсэн дүгнэлтийг үндэслэн 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/48 дугаар захирамжаар "Эко асфальт" ХХК-д хаягдал ус хаях зөвшөөрөл олгож, 3 аж ахуйн нэгжид хаягдал ус хаях зөвшөөрөл олгох захирамжийн төсөл хянагдаж байна. Нийслэлийн Байгаль орчны газраас ирүүлсэн "Ус ашиглуулах дүгнэлт"-ийг үндэслэн 1 аж ахуй нэгжид дүүргийн Засаг даргын захирамжаар ус ашиглах зөвшөөрөл олгохоор захирамжийн төсөл боловсруулагдсан хянах шатанд байна. | 50% |
| 49.2 | Арга хэмжээ: Дүүргийн нутаг дэвсгэрт авто угаалгын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд саарал усны ашиглалтыг нэмэгдүүлэх чиглэлээр | 1.0 | Саарал ус ашигласан авто угаалгын газрын тоо | - | 3-аас доошгүй авто угаалгын газар саарал усны хэрэглээг нэвтрүүлсэн байна. | Дүүргийн нутаг дэвсгэрт авто угаалгын чиглэлээр 28 иргэн, аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаагаас 2 газар саарал усны төхөөрөмжийг нэвтрүүлсэн байна. Саарал усны ашиглалт хангалтгүй байгаатай холбогдуулан саарал усыг үйл ажиллагаандаа бүрэн | 40% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллана. | | | | | нэвтрүүлэх, ашиглаж буй төхөөрөмжийн хүчин чадлыг сайжруулах чиглэлээр нийслэлийн Бизнес инновац хөгжлийн газар, "Алтай эколос" ХХК-тай хамтран 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр саарал усны тоног төхөөрөмж, ногоон зээлд хамрагдах талаар сургалт уулзалтыг зохион байгуулсан. Сургалтад нийт 16 авто угаалгын үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж хамрагдсан. | |
| 50 | **Зорилт 50**<br>Туул тосгон Биокомбинат орчмын хайрганы карьериас үүдэлтэй газрын эвдрэл доройтлын судалгааг хийж, мэргэжлийн байгууллагуудтай хамтран нөхөн сэргээлт хийнэ. /ДЗДҮАХ 5.1.6/ | | Зохион байгуулсан хяналт шалгалтын тоо, хэрэгжилтийн хувь | 38 аж ахуй нэгжид холбогдох ус, газар, байгалийн нөөцийг хуулийн дагуу ашиглаж, нөхөн сэргээж, нөөц ашигласны төлбөрөө хугацаанд нь төлж байгаа эсэхэд 12 удаагийн хяналт шалгалт хийсэн. | Нөхөн сэргээх шаардлагатай газрын хэмжээг тодорхойлж, нөхөн сэргээх ажлын техник эдийн засгийн үндэслэлд тулгуурлан нөхөн сэргээлт хийнэ. | Хан-Уул дүүрэгт түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрөлтэй 37 аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байгаагаас 17 аж ахуйн нэгж, байгууллага олборлолтын үйл ажиллагаа явуулж байна.<br>Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлолтын нөлөөгөөр эвдэрсэн газарт 2022 онд ажлын хэсэг гарган 4 удаа хяналт шалгалтыг хийж, 124.43 га эвдрэлтэй талбайг тогтоосон.<br>Нийгмийн хариуцлагын хүрээнд "Үйлсийн алтан хэлхээ" ТББ-тай хамтарч дүүргийн 13 дугаар хорооны нутагт хайрга дайрга олборлолтын улмаас эвдэрсэн 1 га талбайд техникийн болон биологийн жишиг нөхөн сэргээлтийн ажлыг хэрэгжүүлэхээр, талбайд хуримтлагдсан хог хаядлыг цэвэрлэж байна. | 40% |
| 50.1 | Арга хэмжээ: Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт, тээвэрлэлт, нөхөн сэргээлтэд тавих хяналт шалгалтыг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлнэ. | - | Зохион байгуулсан хяналт шалгалтын тоо, хэрэгжилтийн хувь | 38 аж ахуй нэгжид холбогдох ус, газар, байгалийн нөөцийг хуулийн дагуу | Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт, тээвэрлэлт, нөхөн сэргээлтэд 5- | Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/90, Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны А/53 дугаар захирамжийн хүрээнд 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн түгээмэл тархацтай ашигт малтмалын тээвэрлэлтэд хяналт тавьж, 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар давхардсан тоогоор 7263 | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ашиглаж, нөхөн сэргээж, нөөц ашигласны төлбөрөө хугацаанд нь төлж байгаа эсэхэд 12 удаагийн хяналт шалгалт хийсэн. | аас доошгүй удаагийн хяналт шалгалтыг ажлыг зохион байгуулна. | тээврийн хэрэгсэл шалгаж, зөрчил гаргасан 5137 тээврийн хэрэгслийн жолоочид 130,990,000 төгрөгийн торгууль ноогдуулж, зөрчил арилгах арга хэмжээ авч ажилласан. Дүүргийн Засаг даргын 2023 оны А/151 дүгээр захирамжийн дагуу 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар 11 байгууллагын 158 тээврийн хэрэгслийн хариуцагчтай "Тээвэрлэлтийн хариуцлагын гэрээ"-г байгуулж, хяналт тавин ажиллаж байна. Дүүргийн 12, 13 дугаар хорооны иргэдээс ирүүлсэн гомдлын дагуу тус хороодод үйл ажиллагаа эрхэлдэг түгээмэл тархацтай ашигт малтмал олборлогч аж ахуйн нэгжүүдэд хяналт шалгалтыг 8 удаа зохион байгуулж, зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байсан "Очир шүр" ХХК, "Баян сүмбэр богд" ХХК, "Батадар" ХХК гэсэн 3 аж ахуйн нэгжийн олборлолтын ажиллагааг зогсоох арга хэмжээ авсан. Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 17 аж ахуйн нэгж, байгууллагад батлагдсан удирдамжийн дагуу Хан-Уул дүүрэг дэх Цагдаагийн газар, Онцгой байдлын хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Татварын хэлтэс, Газар зохион байгуулалтын алба, харьяа хороодын Засаг дарга нартай хамтарч 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 26-ны өдрийн хооронд хяналт, шалгалт явуулж, илэрсэн зөрчлийг арилгах чиглэлээр хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллаж байна. | |
| | | | Нөхөн сэргээлт хийсэн талбай, га | 35,3 га газарт техникийн нөхөн сэргээлт, 12,5 га газарт биологийн нөхөн сэргээлт хийсэн байна. | Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлогч аж ахуйн нэгж байгууллагууд тай хамтарч уул уурхайн олборлолтын улмаас эвдэгдсэн 10-аас доошгүй га талбайд нөхөн сэргээлт хийнэ. | | |
| 51 | **Зорилт 51** | - | Арга хэмжээний | - | Спортын 5 төрлөөр | "Хан-Уул дүүргийн Засаг даргын нэрэмжит спортын 5 төрөлт тэмцээн"-ийг | 30% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Дүүргийн төрийн байгууллага, аж ахуйн нэгж байгууллагуудын дунд Засаг даргын нэрэмжит нээлттэй тэмцээнийг жил бүр зохион байгуулна. /ДЗДҮАХ 2.1.2/ | | хэрэгжилтийн хувь | | тэмцээн зохион байгуулна. | 2023 оны 6 дугаар сарын 10-21-ний өдрийн өдрүүдэд зохион байгуулахаар удирдамжийг байгууллагуудад хүргүүлсэн. Тэмцээнд нийт 26 байгууллагын 20 баг өрсөлдөхөөр мэдүүлгээ өгөөд байна. | |
| 51.1 | Арга хэмжээ: Дүүргийн Засаг даргын нэрэмжит нээлттэй тэмцээнийг төрийн байгууллага, ААН-үүдийн дунд жил бүр зохион байгуулна. | 25.0 | Хамрагдсан албан хаагчдын тоо | - | Спортын арга хэмжээнд дүүргийн төрийн болон хувийн аж ахуйн нэгж байгууллагуудын 900-аас доошгүй албан хаагчийг хамруулна. | Төр хувийн хэвшлийн хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Засаг даргын нэрэмжит спортын 3 төрөлт тэмцээнийг зохион байгуулж 35 аж ахуйн нэгжийн 300 гаруй ажилтан, албан хаагчид оролцсон. | 50% |
| 52 | **Зорилт 52** Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөр үе, залуучуудын шигшээ багийг өргөжүүлэн өсвөр үе, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх замаар дэмжлэг үзүүлж, амжилтыг ахиулна. /ДЗДҮАХ 2.1.4/ | - | Арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Тив, дэлхийн наадамд өсвөрийн 29 тамирчин 19 медаль хүртсэн. | Өсвөр үе, залуучуудын оролцоог нэмэгдүүлж, амжилтыг ахиулна. | Хан-Уул дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багт спортын 11 төрлөөр 310 тамирчин бэлтгэл сургуулилт хийж байна. 2023 онд орон нутгийн төсөвт Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагаанд 77.925.0 төгрөгийн санхүүжилтийг төсөвлөж, 30.000.0 төгрөгийг зарцуулсан. 2023 оны эхний хагас жилийн байдлаар дүүргийн өсвөрийн шигшээ баг улсын хэмжээнд спортын 11 төрлөөр 24 удаагийн тэмцээнд нийт 531 тамирчин оролцож алтан медаль 73, мөнгөн медаль 43 хүрэл медаль 74 нийт 176 багц медаль хүртсэн. | 100% |
| 52.1 | Арга хэмжээ: Засаг даргын дэргэдэх өсвөр үе, залуучуудын шигшээ багийг өргөжүүлэн үйл ажиллагааг нь дэмжин ажиллана. | 65.0 | Шигшээ багийн тоо | Спортын 12 шигшээ багийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн. | Спортын 14-өөс доошгүй төрлийн шигшээ багийн үйл ажиллагааг | Хан-Уул дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ баг спортын 11 төрлөөр 310 тамирчин бэлтгэл сургуулилт хийж байна. 2023 онд шинээр Бочи спортын төрлөөр нийслэлийн 63 дугаар сургуультай хамтран хөгжлийн бэрхшээлтэй өсвөрийн тамирчдыг | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дэмжсэн байна. | хичээллүүлж шигшээ багийн тоог нэмэгдүүлэхээр ажиллаж байна. | |
| 52.2 | Арга хэмжээ: Засаг даргын дэргэдэх өсвөр үе, залуучуудын шигшээ багийг Олон улсын уралдаан тэмцээнд бэлтгэж оролцуулна. | 30.0 | Оролцсон тэмцээн уралдааны тоо | 7 удаагийн тэмцээн уралдаанд оролцсон. | Дүүргийн өсвөрийн шигшээ баг тамирчдыг Зүүн Азийн залуучуудын анхдугаар наадамд бэлтгэн оролцуулах. | Казахстаны Алмата хотноо зохион байгуулагдсан Өсвөр үеийн Азийн цомын тэмцээнд дүүргийн өсвөр үеийн шигшээ багийн 4 тамирчин оролцож алтан медаль 1, хүрэл медаль 1 хүртсэн. ОХУ-ын Красноярска хотноо зохион байгуулагдсан "Красноярская лига" жудо бөхийн олон улсын тэмцээнд дүүргийн өсвөрийн шигшээ багийн 11 тамирчин оролцож алтан медаль 4, мөнгөн медаль 1, хүрэл медаль 4 хүртсэн. Монголын хөл бөмбөгийн холбооны "Ub futsal cup 2023" тэмцээн 2023 оны 4 дүгээр сарын 04-ний өдөр Дорноговь аймгийн Сайншанд суманд зохион байгуулагдаж Улаанбаатар хотын аварга Хан-Уул дүүргийн шигшээ баг оролцон Футзалын үндэсний цомын эзэд болсон. | 50% |
| 53 | **Зорилт 53**<br>Бүх шатны боловсрол соёлын байгууллагууд олон улсын байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд олон нийтийн сүлжээг ашиглан соёлын боловсрол олгох "Хотын соёл" олон нийтийн аян өрнүүлнэ./ДЗДҮАХ 2.4.1/ | | Арга хэмжээ /контент/ тоо | 3 шторк, 16 постер | 3-аас дээш цуврал контент, видео шторк байршуулна. | "Хотын соёл-Хорт зуршил" сургалтад дүүргийн нутаг дэвсгэрт байрлах 6 коллежийн 1045 оюутныг хамруулж, "Хотын соёл-Хорт зуршил", "Хотын соёлд-Бидний үйлдэл" сэдэвт илтгэлийн уралдааныг 1, 2 дугаар дамжааны 75 оюутнуудын дунд зохион байгуулсан. Хотын соёл аяны хүрээнд 3 бичлэг, 16 постерыг байгууллагын цахим хуудсанд байршуулсан ба тус бичлэг, постерт 2478 иргэн хандаж, 327 лайк дарж, 154 шэйр хийсэн байна. | 30% |
| 53.1 | Арга хэмжээ: "Хотын соёл-Хан-Уулаас" олон нийтийн соёлын арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулна. | 15.0 | Хамрагдсан иргэдийн тоо | 6500 гаруй иргэнийг хамруулсан. | 5000-аас доошгүй иргэдийг хамруулна. | Сурагчдын өвийн боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор"Өвийн жим" клубээс "Өв бидний бахархал" самбарын үзүүлэн, өв соёлоо танин мэдье аялал зохион байгуулж, "Дэлхийн өв ба түүний ач холбогдол", "Дэлхийн өв ба хүрээлэн буй орчин", "Өвийн боловсрол зэрэг | 30% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сэдвээр 8 удаагийн сургалтад 165 иргэнийг хамруулсан. | |
| 54 | **Зорилт 54** Дүүргийн Эрүүл мэндийн байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, эмч, сувилагчдын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэжил дээшлүүлэх, иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээг чанартай хүргэх зорилгоор "Эрүүл дүүрэг" дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ. /ДЗДҮАХ 2.2.8/ | | Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | Хэрэгжилт 40 хувьд хүрсэн. | Хэрэгжилт 70 хувьд хүрсэн байна. | Нэгдсэн эмнэлгийн Биосалбарт уламжлалт эмчилгээний улаан гэрлийн аппарат-2ш, салбар амбулаторийн эмэгтэйчүүдийн кабинетад ургийн допплер- 2ш, шүдний кабинет болон дурангийн кабинетад 3ш зөөврийн кварц нийлүүлсэн. "Эрүүл дүүрэг" дэд хөтөлбөрийн хүрээнд Тусгай олимпын Дэлхийн зуны наадамд оролцох тамирчдад 4,5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. | 30% |
| 54.1 | Арга хэмжээ: Дүүргийн эрүүл мэндийн төсөвт байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлыг зохион байгуулна. | 200.0 | Үйл ажиллагааны хэрэгжилт | НТХО 404.2 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангасан. | Эрүүл мэндийн байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана. | Нэгдсэн эмнэлгийн Мэс заслын тасгийг Нийслэлийн төсвийн 375,0 сая төгрөгийн санхүүжилтээр хийгдэх засварын ажлын тендэрт "Ти Эйч Эн" ХХК шалгарсан. | 30% |
| 54.2 | Арга хэмжээ: Эрүүл мэндийг дэмжих төв болон нийгмийн эрүүл мэндийн төвийг дүүргийн эрүүл мэндийн байгууллагуудыг түшиглэн байгуулах ажлыг зохион байгуулна. | 800.0 | Байгуулсан Эрүүл мэндийг дэмжих төвийн тоо | 1 /ЭМТ-ийн дэргэд "Эрүүл мэндийг дэмжих төв/ | Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулсан байна. | Нэгдсэн эмнэлэгт "Эрүүл мэндийг дэмжих төв"-ийн засварын ажлыг 2 дугаар улиралд ашиглалтад оруулахаар ажиллаж байна. | 30% |
| 55 | **Зорилт 55** Сургууль, цэцэрлэгийн багш нарын ур чадварыг хөгжүүлэх, чадварлаг багш нарыг урамшуулах, дэмжих, тэдний тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор "Багш" дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ. /ДЗДҮАХ 4.1.2/ | | Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | Хэрэгжилт 50 хувьд хүрсэн. | Хэрэгжилт 75 хувьд хүрсэн байна. | Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны А/52 дугаар захирамжаар "Багш" дэд хөтөлбөр хэрэгжүүлэх 125,0 сая төгрөгийн төсвийг батлуулсан. "Багш" дэд хөтөлбөрийн хүрээнд 3 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүнд: 1. "Хан-Уул дүүргийн Засаг даргын нэрэмжит ерөнхий боловсролын сургуулиудын багш, ажилчдын спортын 5 төрөлт тэмцээн" | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2. Хан-Уул дүүргийн ерөнхий боловсролын сургалтын байгууллага, багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулах төсөл<br>3. Бүгд Найрамдах Болгар Улсад зохион байгуулагдах "Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй" Олон Улсын хуралд оролцох төлөөлөгчийн замын зардалд дэмжлэг үзүүлэх төсөл<br>Сургуулийн менежментийг сайжруулах зорилгоор сайн туршлага түгээн дэлгэрүүлэх ажлыг дүүргийн 17 сургуульд зохион байгуулж 510 багш, удирдах ажилтан хамрагдсан. | |
| 55.1 | Арга хэмжээ: Сургууль, цэцэрлэгийн багш нарын ур чадварыг хөгжүүлэх чиглэлээр үр дүнтэй үйл ажиллагаа явуулах төсөл, арга хэмжээг шалгаруулан хэрэгжүүлнэ. | - | Хэрэгжсэн төсөл, арга хэмжээний тоо | 1 төсөл, арга хэмжээ хэрэгжсэн. | 3-аас доошгүй төсөл, арга хэмжээ хэрэгжүүлнэ. | "Багш" дэд хөтөлбөрийн хүрээнд 38,3 сая төгрөгөөр 3 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүнд:<br>1. "Хан-Уул дүүргийн Засаг даргын нэрэмжит ерөнхий боловсролын сургуулиудын багш, ажилчдын спортын 5 төрөлт тэмцээн"<br>2. Хан-Уул дүүргийн ерөнхий боловсролын сургалтын байгууллага, багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулах төсөл<br>3. Бүгд Найрамдах Болгар Улсад зохион байгуулагдах "Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй" Олон Улсын хуралд оролцох төлөөлөгчийн замын зардалд дэмжлэг үзүүлэх төсөл<br>Сургуулийн менежментийг сайжруулах зорилгоор сайн туршлага түгээн дэлгэрүүлэх ажлыг дүүргийн ерөнхий боловсролын 17 сургуульд зохион байгуулж, 510 багш, удирдах ажилтныг хамруулсан. | 50% |
| 56 | **Зорилт 56**<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн хамгааллын үйлчилгээнд | - | Зохион байгуулсан арга хэмжээ, | 6 арга хэмжээнд | 5-аас доошгүй арга хэмжээнд 4000 хүртэлх | Олон нийтийн оролцоонд тулгуурласан халамжийн үйлчилгээний бүлгийн төсөл хэрэгжүүлэх сонирхолтой 22 иргэний төслийг хүлээн авсан. Оёдол эсгүүр, | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хамруулж, нөлөөллийн олон талт арга хэмжээг хэрэгжүүлнэ. /ДЗДҮАХ 4.2.2/ | | хамрагдсан иргэдийн тоо | 6000 гаруй иргэдийг хамруулсан. | иргэнийг хамруулна. | үсчин, компьютер, солонгос хэлний сургалтад хамрагдсан 45 иргэнд төсөл бичих, орлогын эх үүсвэртэй болох сургалт зохион байгуулсан.<br>Дүүргийн Засаг даргын захирамжаар тусламж дэмжлэг шаардлагатай 36 иргэнд 13.4 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж, 6 өрхөд 5 ханатай гэр олгосон. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хурлаар 71 хүүхэд, эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлаар 989 хүний асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн. | |
| 56.1 | Арга хэмжээ: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн "Уулзалт өдөрлөг", Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах Олон улсын өдөр"-ийг угтсан арга хэмжээ зохион байгуулна. | 10.0 | Хамрагдсан иргэдийн тоо | 250 иргэнийг хамруулсан. | 375-аас доошгүй иргэнийг хамруулсан байна. | Олон улсын абалимпийн 10 дугаар тэмцээн, Тусгай олимпийн дэлхийн зуны наадамд оролцох хөгжлийн бэрхшээлтэй 6 иргэнд 9 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>Дүүргийн Өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээнийг пара бочи, тусгай бочи гэсэн спортын 2 төрлөөр зохион байгуулж, 60 тамирчин, Нийслэлийн аварга шалгаруулах өсвөр үеийн тусгай бочигийн тэмцээнд 12 тамирчин амжилттай оролцсон. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн уулзалт өдөрлөгийг "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах Олон улсын өдөр"-ийг угтан 10 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөн ажилллаж байна. | 50% |
| 56.2 | Арга хэмжээ: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх нэг цэгийн төвийг байгуулна. | 75.0 /УТХО/ | Арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Төвийн гадна, дотор засвар хийгдсэн. | Тусгай хэрэгцээт иргэдэд үйлчлэг нэг цэгийн төвийг ашиглалтад оруулна. | Дүүргийн төсвийн 75,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх нэг цэгийн үйлчилгээний төв"-ийн барилгын дотор сантехник дулааны ажил гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендер 2023 оны 4 | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
